МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР
САНГИЙН ЯАМ

# ИРГЭДИЙН ТӨСӨВ - 2018

## МОНГОЛ УЛСЫН БАТЛАГДСАН ТӨСӨВ



2018 он
УЛААНБААТАР ХОТ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР **САНГИЙН ЯАМ**

Монгол Улсын Сангийн яамны санаачлагаар, Америкийн Нэгдсэн Улсын Засгийн газрын санхүүжилт, дэмжлэгээр “Иргэдийн төсөв-2018” товхимлыг Монгол Улсын 2018 оны батлагдсан төсвийн мэдээллийг иргэдэд хүргэх зорилгоор монгол, англи хэлээр бэлтгэн гаргав.

Товхимлыг олон нийтийн хүртээл болгох нь бидний зорилго тул бүрэн болон хэсэгчлэн арилжааны бус зорилгоор ашиглаж болно. Ийнхүү ашигласан тохиолдолд эх сурвалжийг “Иргэдийн төсөв-2018”, Сангийн яам гэж тодотгоно уу.

Санал хүсэлт болон мэдээлэлтэй холбоотой лавлах зүйл байвал Сангийн яамны tusuv@mof.gov.mn цахим шууданд ирүүлнэ үү.

# МЭНДЧИЛГЭЭ



Төсөв бол тухайн улс орны эдийн засгийн удирдах чадварын толь юм. Иргэн таны төлсөн татвараас бүрдсэн төсөв эргээд нийгмийн сайн сайхан байдлын төлөө зарцуулагдах ёстой хөрөнгө билээ. Тиймээс иргэн Танд төсвийн талаар мэдлэг, мэдээллийг тогтмол өгч төсвийн үйл явцад Таны хяналт, оролцоог нэмэгдүүлэх, ил тод байдлыг сайжруулах зорилгоор “Иргэдийн төсөв” товхимлыг анх удаа боловсруулан толилуулж байна.

Иргэдийн төсөв товхимол нь үндсэн таван хэсгээс бүрдэх бөгөөд эдийн засаг, санхүү төсвийн талаарх үндсэн ойлголтыг Монгол Улсын 2018 оны төсвийн мэдээллээр жишээ болгон “инфографик” буюу “зурган мэдээлэл” хэлбэрээр энгийн ойлгомжтой байдлаар хүргэхийг зорьсон.

Товхимлыг хэвлэмэл байдлаар авч болохоос гадна цахим хэлбэрээр сангийн яамны www.mof.gov.mn, www.iltod.gov.mn хуудас болон олон нийтийн мэдээллийн сүлжээ, сангийн яамны фэйсбүк хуудаснаас үзэж болно. Цаашид “Иргэдийн төсөв” товхимлыг жил бүр боловсруулан гаргаж байхаар төлөвлөж байгаа тул товхимлыг сайжруулах талаарх санал хүсэлтээ бидэнд ирүүлнэ гэдэгт итгэж байна. Энэ дашрамд, товхимлын агуулгыг боловсруулахад оролцсон Сангийн яамны ажилтнууд, зураг, дизайныг бэлтгэсэн “Чадамжид суурилсан боловсролыг дэмжих төв” ТББ болон санхүүжүүлэн хамтран ажилласан Америкийн Нэгдсэн Улсын Сангийн яаманд гүн талархал илэрхийлж байна.

МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД



**ЧИМЭДИЙН ХҮРЭЛБААТАР**



Иргэн гэж тухайн оронд төрсний хувьд тодорхой эрх эдэлж, үүрэг хүлээх субьект юм.
Монгол Улс 2017 оны эцсийн байдлаар **3,177,899** иргэнтэй байна.

Иргэн ТА
Улсынхаа төсвийн
талаар юу мэдэх вэ?

## 1 ИРГЭДИЙН ТӨСӨВ ГЭЖ ЮУ ВЭ?

Ард иргэдэд улсын төсөв, санхүүгийн талаар үндсэн мэдээллийг танилцуулах хэрэгсэл юм. Хэлбэрийн хувьд хэвлэмэл, цахим болон нэг хуудсаас эхлэн бүрэн хэмжээний тайлан ч байж болно.

## 2 АЧ ХОЛБОГДОЛ

- ✓ Иргэд болон иргэний нийгмийн байгууллагуудын төсвийн талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх
- ✓ Төсөвлөлтийн үйл явцад иргэдийн оролцоог хангах
- ✓ Төрийн мөнгийг хэр сайн удирдаж байгаад иргэд хяналт тавих
- ✓ Төсвийн ил тод байдал, үр ашгийг сайжруулах

## 3 ЯАГААД ХИЙХ ХЭРЭГТЭЙ ВЭ?

Интернэйшнэл Баджет Партнершип* олон улсын ТББ-аас үндсэн 8 үзүүлэлтээр "Төсвийн ил тод байдал"-ыг индексжүүлэн тооцож олон улсын түвшинд үнэлдэг. 2017 онд Монгол Улс дэлхийн дундаж үзүүлэлт 42-оос ялимгүй өндөр гарсан.




- Олон нийтэд нээлттэй боловсруулдаг
- Дотоод хэрэгцээнд зориулан боловсруулдаг
- Огт боловсруулдаггүй

## 4 ЯАЖ ХИЙХ ВЭ?

Иргэдийн төсвийн танилцуулга боловсруулах үед анхаарах зүйлс:

- ✓ Иргэд ойлгоход хялбар мэргэжлийн үг хэллэг багатай энгийн ойлгомжтой байх
- ✓ Тухайн улсын албан ёсны хэл дээр гаргах
- ✓ Анхаарал татахуйц зураг, дүрслэлтэй байх

## 5 ХЭН, ХЭЗЭЭ ХИЙХ ВЭ?

Иргэдийн төсвийн танилцуулгыг Засгийн газар боловсруулна. → Төсөв хэлэлцэх үед болон батлагдсаны дараа иргэдэд хүрнэ.



** Интернэйшнэл Баджет Партнершип -Засаглалыг сайжруулах, ядуурлыг бууруулах зорилгоор дэлхий даяар иргэний нийгмийн байгууллагатай хамтран төсвийн дүн шинжилгээ болон төсвийн талаарх соён гэгээрүүлэх ажлыг гүйцэтгэдэг олон улсын ТББ юм.*

# АГУУЛГА


## ТӨСВИЙН ТУХАЙ 5

Төсвийн бүрдэлт, хуваарилалт 5
Нэгдсэн төсвийн бүрэлдэхүүн 6
Төсвийн үе шат 7
Шилэн дансны тухай 10

## МОНГОЛ УЛСЫН 2018 ОНЫ НЭГДСЭН ТӨСӨВ 11

Макро эдийн засгийн төсөөлөл 11
Нэгдсэн төсвийн үзүүлэлтүүд 12
Төсвийн орлогын бүтэц 14
Татварын тухай ойлголт 16

## ТӨСВИЙН ЗАРЛАГА 20

Төсвийн нийт зарлага 20
Засгийн газрын гадаад зээл, тусламж 25
Засгийн газрын өр 26

## 2018 ОНЫ ТӨСВИЙН ОНЦЛОГ 30

2018 оны төсвийн зорилт 30
Төрийн нийтлэг үйл ажиллагаа 31
Нийгмийн хамгаалал 32
Боловсрол 35
Батлан хамгаалах, нийгмийн хэв журам 38
Эрүүл мэнд 39
Эдийн засгийн үйл ажиллагаа 42
Спорт, соёл урлаг, аялал жуулчлал 44
Хүрээлэн буй орчин хамгаалал 45
Хүүхдийг төрөөс хэрхэн анхаардаг вэ? 47
Эх хүнийг төрөөс хэрхэн анхаардаг вэ? 48
Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг төрөөс хэрхэн анхаардаг вэ? 49
Ахмад настанг төрөөс хэрхэн анхаардаг вэ? 50

## ОРОН НУТГИЙН ТӨСӨВ 52

Орон нутгийн төсвийн бүрдүүлэлт 52
Орон нутгийн төсвийн зарцуулалт 53
Улс, орон нутгийн төсвийн харилцаа 54
Орон нутгийн хөгжлийн сан 55
Нийслэлийн 2018 оны төсөв 56

## ХАВСРАЛТ 61

## ТОВЧИЛСОН ҮГ

| | |
|---|---|
| ААН | Аж ахуйн нэгж |
| ААНБ | Аж ахуйн нэгж байгууллага |
| АНУ | Америкийн Нэгдсэн Улс |
| АХБ | Азийн хөгжлийн банк |
| БНСУ | Бүгд Найрамдах Солонгос Улс |
| БНФУ | Бүгд Найрамдах Франц Улс |
| БНХАУ | Бүгд Найрамдах Хятад Ард Улс |
| БНЭУ | Бүгд Найрамдах Энэтхэг Улс |
| БСШУС | Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спорт |
| ДНБ | Дотоодын нийт бүтээгдэхүүн |
| ЕБС | Ерөнхий боловсролын сургууль |
| ИТХ | Иргэдийн төлөөлөгчдийн хурал |
| МБС | Мэргэжлийн боловсрол, сургалт |
| МСК | Мянганы сорилтын корпораци |
| МСҮТ | Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв |
| МЦХ | Монголын цахилгаан холбоо |
| НДШ | Нийгмийн даатгалын шимтгэл |
| НӨАТ | Нэмэгдсэн өртгийн албан татвар |
| ОУВС | Олон улсын валютын сан |
| ОХУ | Оросын Холбооны Улс |
| ӨҮЦ | Өнөөгийн үнэ цэнэ |
| ТББ | Төрийн бус байгууллага |
| ТЕЗ | Төсвийн ерөнхийлөн захирагч |
| ТӨҮГ | Төрийн өмчит үйлдвэрийн газар |
| ТТЗ | Төсвийн төвлөрүүлэн захирагч |
| ТШЗ | Төсвийн шууд захирагч |
| УИХ | Улсын Их Хурал |
| ҮНО | Үндэсний нийт орлого |
| ҮОМШӨ | Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин |
| ХАА | Хөдөө аж ахуй |
| ХБИ | Хөгжлийн бэрхшээлтэй иргэн |
| ХБГ | Хүлээгдэж буй гүйцэтгэл |
| ХБНГУ | Холбооны Бүгд Найрамдах Герман Улс |
| ХЗДХ | Хууль зүй, дотоод хэрэг |
| ХК | Хувьцаат компани |
| ХНХ | Хөдөлмөр, нийгмийн хамгаалал |
| ХХААХҮ | Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр |
| ХХОАТ | Хувь хүний орлогын албан татвар |
| ШУ | Шинжлэх ухаан |
| ЭЗХАХБ | Эдийн засгийн хамтын ажиллагаа хөгжлийн байгууллага |
| ЭМД | Эрүүл мэндийн даатгал |

# БҮЛЭГ 1. ТӨСВИЙН ТУХАЙ

## ТӨСВИЙН БҮРДЭЛТ, ХУВААРИЛАЛТ

**Төсөв** нь Монгол Улсын эдийн засаг, нийгмийн зорилтыг хэрэгжүүлэх хэрэгсэл бөгөөд тухайн оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэлх хугацаанд төрийн санд хуримтлагдах нийт орлого, түүнийг зарцуулах арга хэмжээг багтаасан орлого, зарлагын тэнцэл юм.

**Төсвийн орлого** нь татварын болон татварын бус орлого, тусламжаас бүрддэг. Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт орлогоос Төсвийн тогтворжуулалтын сан болон Ирээдүйн өв санд ногдох хэсгийг хасаад үлдсэн орлогыг Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого гэнэ.




**Төсвийн зарлага** нь урсгал болон хөрөнгийн зардлаас бүрдэнэ. Төсвийн зарлага нь төрөөс иргэдэд боловсрол олгох, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, улс орны аюулгүй байдлыг хангах, дэд бүтцийг хөгжүүлэх, нийгмийн хамгааллын үйлчилгээ үзүүлэх зэрэг төрийн үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд зарцуулагддаг.

**Төсвийн тэнцэл буюу төсвийн ашиг, алдагдал** Тухайн төсвийн жилийн орлого, зарлагын зөрүүг төсвийн тэнцэл гэх бөгөөд зарлагаас давсан орлогыг төсвийн ашиг, орлогоос давсан зарлагыг төсвийн алдагдал гэнэ. Төсвийн ашиг ба алдагдлыг Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувиар илэрхийлэх бөгөөд төсвийн алдагдлыг Засгийн газрын бонд, гадаад зээлийн эх үүсвэрээр санхүүжүүлдэг бол төсвийн ашгийг ирэх жилийн төсвийн эх үүсвэрт зарцуулдаг.

## НЭГДСЭН ТӨСВИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Монгол Улс нэгдсэн төсөвтэй. Улсын төсөв, Нийгмийн даатгалын сангийн төсөв, Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв, Орон нутгийн төсөв нь нэгдсэн төсвийн бүрдэл болдог. Орон нутгийн төсөв нь аймаг, нийслэл, сум, дүүргийн төсвөөс бүрдэнэ.

Улсын Их Хурал нь Улсын төсөв, Нийгмийн даатгалын сангийн төсөв, Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийг баталдаг бол орон нутгийн төсвийг тухайн шатны Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар баталдаг.




### УЛСЫН ТӨСӨВ

Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газар, яамд болон тэдгээрийн харьяа байгууллагуудын бүрдүүлж, хуваарилан зарцуулах төсвийг улсын төсөв гэнэ. Улсын төсөв нь нэгдсэн төсвийн 80% орчмыг эзэлдэг.

### ОРОН НУТГИЙН ТӨСӨВ

Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар баталсан аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын бүрдүүлэн зарцуулах төсвийг хэлнэ. Орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг болон улсын төсөвт төвлөрүүлэх орлогын хэмжээг Улсын Их Хурал баталдаг.

### НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСӨВ

Нийгмийн даатгалын хуулийн дагуу ажилтан болон ажил олгогчоос төлсөн нийгмийн даатгалын шимтгэл, улсын төсвөөс олгосон санхүүжилтээр бүрдүүлсэн орлогоор Нийгмийн даатгалын хуулиудад заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийг санхүүжүүлэхэд зарцуулдаг.

### ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСӨВ

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн дагуу төр, иргэн, байгууллагаас төлсөн эрүүл мэндийн даатгалын шимтгэлээр эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлыг санхүүжүүлэхэд зарцуулдаг.

## ТӨСВИЙН ҮЕ ШАТ

Төсөв нь боловсруулах, батлах, хэрэгжүүлэх, гүйцэтгэлд үнэлгээ хийх гэсэн дөрвөн үе шат бүхий гурван жил дамнасан тасралтгүй үйл ажиллагаа юм. Төсвийн үе шат бүрд төсвийн баримт бичиг боловсруулагддаг.



**БАРИМТ БИЧИГ**
- Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл
- Төсвийн хязгаар
- Төсвийн төсөл, танилцуулга
- Хүрэх үр дүнгийн үзүүлэлт

**БАРИМТ БИЧИГ** (тухай оны)
- Монгол Улсын төсвийн тухай хууль
- Нийгмийн даатгалын сангийн төсвийн тухай хууль
- Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн тухай хууль батлагдана

**БАРИМТ БИЧИГ**
- Сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээ
- Улирал, хагас жилийн тайлан
- Жилийн эцсийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан

**БАРИМТ БИЧИГ**
- Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан
- УИХ-аар батлагдсан жилийн төсвийн гүйцэтгэл




Төсвийн тухай хуулиар төсвийн үе шатанд оролцогч талуудын эрх үүрэг, харилцааг зохицуулсан байдаг. Төсвийн захирагч гэдэг нь эрхлэх асуудлын хүрээний төсвийг төлөвлөх, батлагдсан төсвийг хуваарилах, хяналт тавих, захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг хэлнэ.



### ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ (ТЕЗ)

Төсвийн ерөнхийлөн захирагч нар нь холбогдох салбар, чиглэлийн хувьд төсвийг захирах дээд удирдлага юм. Чиг үүргээ төсвийн төвлөрүүлэн захирагч, төсвийн шууд захирагч нараар дамжуулан хэрэгжүүлдэг. Тухайлбал: УИХ-ын харьяа байгууллагын дарга, яамдын сайд, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга нар гэх мэт.

*Жишээ: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд*



### ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ (ТТЗ)

Төсвийн ерөнхийлөн захирагч болон төсвийн шууд захирагч нарыг холбогч төрийн байгууллагын удирдлага. Ихэвчлэн орон нутагт салбар нэгжтэй агентлагийн дарга байдаг бөгөөд зарим салбарын хувьд бүтцээс хамааран төсвийн төвлөрүүлэн захирагчгүй байж болно.

*Жишээ: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар*



### ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ (ТШЗ)

Энэ нь тухайн төсвийн ерөнхийлөн захирагчийн анхан шатны түвшинд үйл ажиллагаа явуулдаг төрийн байгууллагын удирдлага юм.

*Жишээ: Архангай аймгийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн дарга*

## ТӨСӨВ БОЛОВСРУУЛАХ, БАТЛАХ ЦАГЛАБАР

Төсөв боловсруулах, батлахад төсвийн бүх байгууллага оролцдог төдийгүй цаг хугацаа, дэс дараалал бүхий үйл ажиллагаа тул төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд төсвийн цаглабрыг нарийвчлан заасан байдаг.




### Төсөв боловсруулахад баримталдаг бодлогын баримт бичгүүд

- Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал- 2030
- Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр
- Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл
- Засгийн газраас баталсан үндэсний хөтөлбөрүүд

## ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ, ТАЙЛАГНАЛ, АУДИТЫН ЦАГЛАБАР

Төсвийн захирагч нарын тайланд аудитын дүгнэлт гаргуулах, дээд шатны захирагчид хүргүүлэх, нэгтгэх, улмаар нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланг батлах цаглабрыг доор харуулав.




### ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

Тухайн оны 1 дүгээр сарын 1-ээс эхлэн төсөв зарцуулах эрх нээгдэх бөгөөд 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болдог. Татварын ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар болон бусад орлого төвлөрүүлэх үүрэгтэй байгууллагууд нь төсвийн орлогыг төрийн санд төвлөрүүлдэг ба батлагдсан төсвийн хуваарийн дагуу төрийн сангаас төсвийн байгууллагад санхүүжилт олгож, төлбөр тооцоог гүйцэтгэдэг.

### ТӨСВИЙН ТАЙЛАГНАЛ

Сар бүр төсвийн гүйцэтгэлийн мэдээг төсвийн байгууллагууд гаргаж тогтоосон хугацаанд дээд шатны захирагчид хүргүүлдэг. ТЕЗ нар мэдээллийг нэгтгээд Сангийн яаманд хүргүүлнэ. Сангийн яам мэдээг нэгтгэн гаргаж сар бүрийн 8-ны дотор Үндэсний статистикийн хороонд хүргүүлэн олон нийтэд мэдээлдэг.
Харин улирал, хагас жил, бүтэн жилээр төсвийн байгууллагууд санхүүгийн тайланг гаргаж дээд шатны захирагчид хүргүүлдэг. Аудитын байгууллагаар жилийн эцсийн санхүүгийн тайланд заавал аудит хийлгэдэг. Сангийн яам төсвийн ерөнхийлөн захирагчдын аудит хийлгэсэн тайланг нэгтгэн Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, нэгдсэн төсвийн гүйцэтгэлийг гарган Үндэсний аудитын газарт хүргүүлнэ. Үндэсний аудитын газар нь тайланд аудит хийж, аудитын дүгнэлтийн хамт Засгийн газар, УИХ-д өргөн мэдүүлдэг. УИХ нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланг хаврын чуулганаар хэлэлцсэнээр Монгол Улсын төсвийн гүйцэтгэл батлагддаг.

### ТӨСВИЙН ХАРИУЦЛАГА

Улсын төвлөрсөн төсвийн гүйцэтгэлийг Засгийн газар УИХ-ын өмнө хариуцдаг бол орон нутгийн төсвийн хувьд гүйцэтгэлийг бүх шатны засаг дарга тухайн шатны ИТХ-ын өмнө хариуцдаг.

# ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ

Төсвийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах, ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих тогтолцоо бол шилэн данс юм. Шилэн дансны тухай хуулиар шилэн дансанд мэдээлэл байршуулах байгууллага болон мэдээллийг хэдий хугацаанд, ямар давтамжтай тавихыг нарийвчлан зохицуулсан байдаг.

Төрийн байгууллага: **5634**

Системд бүртгэлтэй нийт байгууллагын тоо: **6905**

Хувийн хэвшлийн байгууллага: **1221**

БҮРТГЭЛТЭЙ БАЙГУУЛЛАГА

Шилэн данс

Төсвийн зарцуулалтад иргэдийн хяналт тавих хэрэгсэл

Шилэн дансны тухай хууль

БАТЛАГДСАН 2014 он — ХЭРЭГЖИЖ ЭХЭЛСЭН 2015 он

ИРГЭД

Төсвийн байгууллагын цахим хуудасны "Шилэн данс" цэс

Нэгдсэн цахим хуудас www.shilendans.gov.mn

Төсвийн байгууллагын Мэдээллийн самбар

www.shilendans.gov.mn

2017 онд нийт **824,094** мэдээлэл байршуулсан.

*«Монгол Улсын иргэд дэлхийн өнцөг булан бүрээс төсвийн мэдээллийг шилэн данснаас авч байна.»*

2017 онд нийт **418,802** хандалт хийгдсэн.

**1,232 — САНГИЙН ЯАМ**

- Засгийн газрын зээл, тусламж, өр, үнэт цаасны мэдээлэл
- Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн мэдээ
- Төсөв, макро эдийн засгийн судалгаа
- Концесстой холбоотой мэдээлэл
- Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, аудитын дүгнэлт

**806,379 — ТӨСВИЙН БАЙГУУЛЛАГА, ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР**

- Худалдан авах ажиллагааны мэдээлэл
- Төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлбар
- Төсвийн тухай мэдээлэл
- Санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт
- 5 сая төгрөгнөөс дээш үнийн дүнтэй худалдан авалт

**4,352 — НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР**

- Нийгмийн даатгалын сангаас олгох, тэтгэвэр, тэтгэмж төлбөр авах эрх бүхий этгээдүүд

**5,857 — ТӨРИЙН ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ ХУВЬЦААТ КОМПАНИ**

- Засгийн газар, орон нутгийн өрийн бичиг
- Тендер шалгаруулсан тухай мэдээлэл
- Концесс
- Төсвийн өр авлага үүсгэх шийдвэр
- Баталгаа, батлан даалтын мэдээлэл

**6,274 — ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ГҮЙЦЭТГЭЖ БУЙ ААН, БАЙГУУЛЛАГА**

- 10 сая төгрөгнөөс дээш ажил үйлчилгээний гүйцэтгэлийн талаарх мэдээлэл

| Улс | Хандалт | Хувь |
|---|---|---|
| Монгол | 404,721 | 97% |
| АНУ | 2,921 | 0.7% |
| ОХУ | 1,617 | 0.4% |
| БНСУ | 1,406 | 0.3% |
| Япон | 875 | 0.2% |
| БНХАУ | 819 | 0.1% |
| Индонез | 501 | 0.1% |
| Хонг Конг | 471 | 0.1% |
| Герман | 441 | 0.1% |
| Бусад орон | 5,030 | 1.2% |

Хандалт хийсэн төхөөрөмжийн хувьд:

- Компьютер — 91%
- Гар утас, хөдөлгөөнт төхөөрөмж — 9%

## ИРГЭН ТАНЫ ХЯНАЛТ, ОРОЛЦОО

- Иргэн та төсвийн мэдээллийг төсвийн байгууллагын мэдээллийн самбар, "Шилэн данс" цэс, www.shilendans.gov.mn авах боломжтой.
- Шилэн дансны мэдээллийн зөрчил, дутагдал болон шаардлагыг цахим хуудас дээрх тухайн байгууллагын утсаар эсвэл бичгээр мэдэгдэнэ.
- Хэрэв тухайн байгууллага иргэн таны тавьсан шаардлагыг хүлээн аваагүй тохиолдолд та гомдол, мэдээллийг төрийн аудитын байгууллагад гаргах эрхтэй.
- Төрийн аудитын байгууллага нь авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнг тухайн иргэнд бичгээр болон олон нийтэд мэдээлнэ.
- Эрх ашиг зөрчигдсөн гэж үзвэл захиргааны хэргийн шүүхээр шийдвэрлүүлэх эрхтэй.

# БҮЛЭГ 2. МОНГОЛ УЛСЫН 2018 ОНЫ НЭГДСЭН ТӨСӨВ

## МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТӨСӨӨЛӨЛ

Төсвийн орлогын төлөвлөгөөг макро эдийн засгийн таамаглалууд дээр үндэслэн тооцдог. Төсвийн зарлагыг Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал–2030 болон бусад бодлогын баримт бичигт үндэслэн боловсруулдаг.

### МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТӨСӨӨЛӨЛ

#### ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН

**30,386.9** ▲ **11.9%** 2017 оноос




#### ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ

**7.0%** ▲ **1.9 пункт** 2017 оноос




#### ИНФЛЯЦИЙН ТҮВШИН

**7.8%** ▲ **1.4 пункт** 2017 оноос




#### ГАДААД ХУДАЛДААНЫ ЭРГЭЛТ

(сая ам.доллар)

**10,975.0** ▲ **4.2%** 2017 оноос




*2018* - Хүлээгдэж буй гүйцэтгэл*
*2018** - 1 дүгээр улирлын гүйцэтгэлд үндэслэн тооцов.*

### МОНГОЛ УЛС 2030 ОН ГЭХЭД:

1. Нэг хүнд ногдох ҮНО 17,500 ам.доллар
2. Эдийн засгийн жилийн дундаж өсөлт 6.6%-аас доошгүй
3. Ядуурлын бүх төрлийг эцэс болгоно
4. Хүн амын 80% нь чинээлэг дундаж давхаргад багтана
5. Суурь, мэргэжлийн боловсролын хамрагдалт 100%
6. Дундаж наслалт 78
7. Хүний хөгжлийн үзүүлэлтээр эхний 70 орны нэг болно
8. Эко-эдийн засгийн үзүүлэлтээр эхний 30 орны нэг болно
9. Бизнесийн орчин, өрсөлдөх чадвараар 70 оронд багтана
10. Чадвартай, авлигагүй, оролцоог хангасан, тогтвортой засаглал

### ХӨГЖЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

#### ХҮНИЙ ХӨГЖЛИЙН ИНДЕКС (ХХИ)

**0.735** ▲ 92-р байрт 188 орноос

*<<Монгол Улс хүний хөгжлийн индексээр өндөр оронд орж байна>>*




*Эх сурвалж: www.undp.org*

#### ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН ИНДЕКС

**3.9** ▲ **101-р байрт** 137 орноос




*Эх сурвалж: The Global Competitiveness Report 2017-2018*

# НЭГДСЭН ТӨСВИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Монгол Улсын төсвийн сүүлийн 11 жилийн өөрчлөлтийг авч үзэхэд 2018 оны төсвийн орлогыг 2008 онтой харьцуулахад 3.6 дахин, нийт зардал 3.9 дахин тус тус өссөн байна. Харин энэ хугацаанд ДНБ 4.6 дахин өссөн бөгөөд энэ нь эдийн засаг, инфляци, дундаж цалин хөлсний өсөлтөөс шууд хамааралтай. Үүнээс гадна тухайн үед авч хэрэгжүүлж байсан төсвийн бодлогын шийдвэрүүдтэй холбоотой.

## 2010 Төсвийн эрх зүйн шинэчлэл

- Дэлхийн зах зээл дээр эрдэс, түүхий эдийн үнэ өндөр үед буюу 2007-2008 онуудад төсвийн орлого ихээхэн нэмэгдсэн. Үүнтэй холбоотойгоор хөрөнгө оруулалт болон нийгмийн хөтөлбөрүүд тухайлбал хүүхдийн мөнгө, шинэ гэр бүл гэх мэт арга хэмжээг санхүүжүүлэх болсон.
- 2009 онд тохиосон дэлхийн санхүүгийн хямрал болон эрдэс баялгийн түүхий эдийн үнийн уналт үргэлжилснээр хөрөнгө оруулалт болон нийгмийн шинжтэй зарлагыг үргэлжлүүлэн санхүүжүүлэхэд бэрхшээлтэй болсон.
- Иймд төсвийн эрх зүйн шинэчлэлийг хийж Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг 2010 онд, Төсвийн тухай хуулийг 2011 онд баталж 2013 оноос хэрэгжүүлсэн.

## 2015 Төсөл хөтөлбөрүүдийг төсөвт нэгтгэсэн

- Хөгжлийн банк, Засгийн газрын гадаад, дотоод зах зээлд 2012 оноос эхлэн гаргасан бондоор санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрүүдийг төсөвт оруулан тооцдоггүй байв.
- Нэгдсэн төсвийн тэнцэл 2013-2015 онуудад ДНБ-ий 1.3-5.0% хүртэл алдагдалтай гарсан ба төсвийн гадуурх зарцуулалт ДНБ-ий 3.1-12.7% байсан.
- Төсвийн нэгдмэл байдлыг хангахын тулд 2015 оноос төсвийн гадуур хэрэгжиж байсан төсөл, хөтөлбөрийн зардлыг төсөвт суулгадаг болсон.

## 2017 ОУВС-ийн хөтөлбөрт хамрагдав

- Монгол Улсын эдийн засаг 2016 онд хүнд байдалд орсон тул "Сэхээн"-д орсон гэж зүйрлэн томъёолж байв.
- Төсөвт тусгаагүй болovч 2016 оны УИХ-ын сонгуулиас өмнө хэрэгжүүлсэн тэтгэврийн нэмэгдэл, "сайн" хөтөлбөрүүд, "Барих-шилжүүлэх" концессын санхүүжилт, гүйцэтгэгч компаниудын өр төлсөн нь төсөвт их хэмжээний дарамт учруулж алдагдал ДНБ-ий 15.1%-д хүрсэн.
- Чингис бондын 500 сая ам.долларын төлбөрийг 2017 оны 12 сар, 2018 оны 1 сард төлөх хуваарьтай байсан ч төлөх эх үүсвэр шийдэгдээгүй байсан зэрэг нь ОУВС-ийн өргөтгөсөн хөтөлбөрт хамрагдах урьдач нөхцөл болсон.

## Шинэчлэлийн үр дүн

- Макро түвшин дэх төсвийн нийт орлого, зарлага, улсын өр төлбөрийн зохистой хэмжээг дүрмийн дагуу тогтоосон.
- Уул уурхайн баялгийн орлогоос эдийн засгийг тогтворжуулахад чиглэсэн хуримтлал үүсгэж эхэлсэн.
- Төсвийн үр ашгийг дээшлүүлэхэд оролцогч талуудын эрх үүрэг, хяналт, хариуцлагыг тогтоон төсвийн ил тод байдал, олон нийтийн оролцоог хангах асуудлыг хуульчилж өгсөн.
- Төсвийн бүтэц, шатлал, ангилал, орлогын эх үүсвэрийг зохих шатны төсөвт хуваарилах, мөнгөн хөрөнгийн болон өр төлбөрийн удирдлагын тогтолцоог бүрдүүлсэн.
- Төсвийн төвлөрлийг сааруулан орон нутагт санхүүгийн тодорхой эрх мэдлийг шилжүүлсэн.

## Төсөвт нэгтгэсний үр дүн

- Төсөвт 2015 онд 433.7 тэрбум төгрөг, 2016 онд 882.8 тэрбум төгрөг, 2017 онд 244.3 тэрбум төгрөгийн төсвийн гадуурх зардлыг нэмж тусгасан.
- Төсвийн сахилга батыг сайжруулж, нэгдсэн нэг төсөвтэй болсон.
- Төсвийн гадуурх зардлыг төсөвт суулгаснаар төсвийн алдагдал огцом нэмэгдэхэд нөлөөлсөн.

## "Өргөтгөсөн санхүүжилт"-ийн хөтөлбөрт хамрагдсаны үр дүн

- Монгол Улсад хийх хөрөнгө оруулалт болон зээлийн хэмжээ нэмэгдэх хөшүүрэг болсон.
- Гадаад валютын нөөц нэг жилийн дотор 2.5 дахин нэмэгдэж, 3 тэрбум ам.доллар, эдийн засгийн өсөлт 1.2%-аас 2017 онд 5.1% болсон.
- Америк долларын ханш 2016 онд 2,490 төгрөгт хүрсэн бол 2017 оны эцэст 2,427 төгрөг болж буурсан.
- Төсвийн сахилга батыг чангатгах, нэгдмэл байдал, үр ашгийг сайжруулан тогтвортой орлогын эх үүсвэрийг бий болгон алдагдлыг үе шаттайгаар бууруулахыг зорьж байна. Тухайлбал алдагдлыг 2018 онд ДНБ-ий 8%, 2019 онд 6.1%, 2020 онд 4.3% хүргэнэ.

Монгол Улсын 2018 оны нэгдсэн төсвийг боловсруулахад төсвийн орлогод учирч болзошгүй эрсдэлийг тооцон, төсвийн орлогыг бодитойгоор төсөвлөх, Засгийн газрын мөрийн хөтөлбөрт тусгасан зорилтыг үе шаттайгаар хэрэгжүүлэх, орон нутгийн төсөвт хийгдэх хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, Засгийн газрын өндөр хүүтэй үнэт цаасны хэмжээг багасгаж, хүүгийн түвшинг бууруулах зарчмыг баримталсан.

**Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл 2008-2018 (тэрбум төгрөг)**




Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлогын хэмжээ 2018 онд 7,231.4 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 23.8%, нийт зарлага 9,651.5 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 31.8%, нэгдсэн төсвийн нийт алдагдал 2,420.1 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 8%-тай тэнцэхээр байна.



## ТӨСВИЙН ОРЛОГЫН БҮТЭЦ

Монгол Улсын төсвийн нийт орлогыг 2018 онд 7,862.9 тэрбум төгрөгөөр, үүнээс тогтворжуулалтын сан 122.8 тэрбум төгрөг, Ирээдүйн өв сан 508.7 тэрбум төгрөг хуваарилж төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг 7,231.4 тэрбум төгрөг байхаар баталсан. Монгол Улсын төсвийн нийт орлого түүнд нөлөөлөгч хүчин зүйлс болон тухайн төсвийн жилийн тэнцвэржүүлсэн орлогыг бүрдүүлдэг татварын болон татварын бус орлогыг төсвийн бүрэлдэхүүн бүрээр дараах зургаар харуулав.



## ТӨСВИЙН ОРЛОГОД НӨЛӨӨЛӨХ ХҮЧИН ЗҮЙЛ

Улс орны эдийн засгийн эрэлт, нийлүүлэлт, өсөлт, экспорт, импорт, дэлхийн зах зээл дээрх эрдэс бүтээгдэхүүний үнэ, томоохон төслүүдийн үйл ажиллагаа, улс төрийн байдал, гадаадын хөрөнгө оруулалт, дэлхийн болон хөрш орнуудын эдийн засгаас ихээхэн хамаарч төсвийн орлого хэлбэлздэг.
Монгол Улсын төсвийн орлогын дийлэнх хувийг бүрдүүлэгч импортоос хамаарах орлого, түүний бүтэц болон уул уурхай салбарын орлогыг эх үүсвэрээр дараах зургаар харуулав.




## ИМПОРТООС ХАМААРАХ ОРЛОГО (2,194.2 тэрбум төгрөг)

### Импортоос хамаарах орлогын бүрдэл (2018 оны төсөөлөл)




### Монгол Улсад томоохон импортлогч орнууд (2017 он)




## УУЛ УУРХАЙН САЛБАРЫН ОРЛОГО (1,720.0 тэрбум төгрөг)

Манай улс зэс, нүүрс, цайр, төмрийн хүдэр, жонш, гянтболд, молибдени, хар тугалга, цагаан тугалга, манган, алт, лити, занар зэрэг эрдэс бүтээгдэхүүн экспортлодог.

**2018 онд уул уурхайн салбараас төсөвт төвлөрүүлэх орлогын төсөөлөл**

| ТӨРӨЛ | ЗЭС | НҮҮРС | АЛТ | ТӨМРИЙН ХҮДЭР | ЦАЙР | БУСАД |
|---|---|---|---|---|---|---|
| ЭКСПОРТЛОХ ХЭМЖЭЭ | 1,366 мян тонн | 28 сая тонн | 21* тонн | 7.5 сая тонн | 106.6 мян тонн | |
| НЭГЖИЙН ҮНЭ, $ | 6,430$ тонн | 60$-100$ тонн | 1,291$ унци | 50$-64$ тонн | 2,241.8$ тонн | |
| ТӨСВИЙН ОРЛОГО | 1,007 тэрбум төг | 495.5 тэрбум төг | 80.4 тэрбум төг | 57.0 тэрбум төг | 42.6 тэрбум төг | 37.5 тэрбум төг |

нийт **1,720** тэрбум төг

| Уул уурхайн орлого татварын төрлөөр (2018 оны төсөөлөл) | | |
|---|---|---|
| 806.3 тэрбум төг | Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр | |
| 390.1 тэрбум төг | Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар | |
| 55.8 тэрбум төг | Гаалийн хураамж | |
| 47.8 тэрбум төг | Ногдол ашиг | |
| 420.0 тэрбум төг | Бусад татвар | |

* Дотоодод тушаах алтны хэмжээ

# ТАТВАРЫН ТУХАЙ ОЙЛГОЛТ

Монголын түүхэн эх сурвалжуудад “Төр оршихуй дор татвар буй, татвар буй дор төр оршимой” хэмээсэн нь төр байгаа цагт татвар байхыг тодорхой дурьдсан байдаг. Түүнчлэн “Албан татвар төлөх нь” иргэний үндсэн үүрэг хэмээн Монгол Улсын Үндсэн хуулийн 17 дугаар зүйлийн 1.3-д хуульчилсан.

## ТАТВАР ЯАГААД ТӨЛДӨГ ВЭ?

Татвар төлснөөр иргэд төрийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлэхэд өөрийн биеэр оролцож байгаа төдийгүй эргээд татварын орлогоор санхүүжсэн нийгмийн үйлчилгээг хүртдэг. Татвар нь дараах гурван зорилгыг хангадаг.

**ТӨСВИЙН ЭХ ҮҮСВЭРИЙГ БҮРДҮҮЛЭХ**

Татвар нь төсвийн орлогын дийлэнх хувийг бүрдүүлдэг тул төрийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг санхүүжүүлэх гол эх үүсвэр болдог.

**ЗОХИЦУУЛАХ**

Татварын бодлого, хувь хэмжээг тогтоох замаар иргэд, ААНБ-ыг дэмжих, хязгаарлах, татвар хураалтыг сайжруулахад чиглэсэн урамшуулал, хөнгөлөлт чөлөөлөлт зэргээр зохицуулдаг.

**ДАХИН ХУВААРИЛАХ**

Татварын орлогыг төрийн чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор бүрдүүлж дахин хуваарилалт хийдэг. Тухайлбал, сургууль, цэцэрлэг, эмнэлэг, төрийн албан хаагчийн цалин, тэтгэвэр, тэтгэмж гм.

## АВТОМАШИНЫ ТАТВАР ЯАГААД ТӨЛДӨГ ВЭ?

Судалгаагаар авто машинаар 1.6 км явах нь нийгэмд 10.9 центийн зардалтай тэнцэх сөрөг үр дагавар үүсгэдэг болохыг тодорхойлсон.




*Эх сурвалж: Parry, Walls & Harrington, 2007*
**1 ам долларыг 2,400 төгрөгөөр тооцов.*

Тус судалгааны үр дүнг төгрөгт шилжүүлэн тооцоход 1км зам туулахад 288 төгрөг, дунджаар өдөрт 20 км зам туулна гэвэл сард 172,800 төгрөгийн зардлыг нийгэм, эдийн засагт зөвхөн нэг машин учруулахаар байна.

Иймд автомашин эзэмшигчээс авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн татвар, онцгой албан татвар авах замаар нийгмийн энэхүү сөрөг үр дагаврыг бууруулахад чиглэсэн арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулдаг.

## ТАТВАРЫН АЧААЛАЛ

Татварын ачааллыг ДНБ-д эзлэх татварын орлогын хэмжээгээр тодорхойлдог бөгөөд энэ үзүүлэлт нь эдийн засаг дахь төрийн оролцоог харуулдаг. Монгол Улсын хувьд татварын ачаалал дундаж түвшинд байна.



## ТАТВАРЫН БОЛОН ТАТВАРЫН БУС ОРЛОГО

Монгол Улсын 2018 оны батлагдсан төсвийн тэнцвэржүүлсэн орлого 7,231.4 тэрбум төгрөг байгаагаас 86.7% нь татварын орлого, 13.3% нь татварын бус орлогоос бүрдэж байна. Татвар төлөгчдийн орлого, ашиг, эд хөрөнгийн үнийн дүнгээс хамааруулан хуульд заасан хувь, хэмжээгээр төрөөс хураан авч байгаа мөнгийг татвар гэдэг бөгөөд Улсын Их Хурлын тогтоосон хязгаарт багтаан Засгийн газар, Иргэдийн төлөөлөгчдийн хурал татварын хувь хэмжээг тогтоодог.

### ТАТВАРЫН ОРЛОГО (тэрбум төгрөг)

**ХУВЬ ХҮНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАР**

716.5 ▲ 19% 2017

Ажил эрхлэгч 900 мянга гаруй иргэний орлогоос 10%.

**АЖ, АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАР**

691.4 ▼ 4% 2017

83.4 мянга гаруй ААНБ-ын орлогын хэмжээнээс хамаарч 10-25%

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН ОРЛОГО**

1,431.1 ▲ 15% 2017

Цалин болон түүнтэй адилтгах орлогоос
Ажил олгогч 12%
Ажилтан 11%

**ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН ТАТВАР**

73.6 ▲ 18% 2017

Хөрөнгийн үнэлгээнээс хамаарч 0.6-1.0%

**АВТОТЭЭВРИЙН БОЛОН ӨӨРӨӨ ЯВАГЧ ХЭРЭГСЛИЙН ТАТВАР**

36.3 ▲ 4% 2017

Машины төрлөөс хамаарч жилд 1,800-720,000 төгрөг

**НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАР**

1,517.3 ▲ 4% 2017

НӨАТ

Бараа, ажил, үйлчилгээний үнийн дүнгийн 10%

**ОНЦГОЙ АЛБАН ТАТВАР**

684.3 ▲ 34% 2017

Архи, тамхи, пиво, бензин үйлдвэрлэгч болон импортлогчоос авдаг татвар

**ГААЛИЙН АЛБАН ТАТВАР**

536.9 ▲ 10% 2017

Импорт дийлэнх бараанд 5%, Экспорт мод, зүсмэл материалаас бусад 0%

**БУСАД АЛБАН ТАТВАР**

580.3 ▲ 9% 2017

ТАТВАР

Газар, байгалийн нөөц ашиглалтын төлбөр, хураамж гэх мэт

### ТАТВАРЫН БУС ОРЛОГО

**НИЙТЛЭГ БУС ТАТВАРЫН ОРЛОГО**

544.3 ▲ 17% 2017

Ноогдол ашиг, хүү торгууль, навигаци, газрын тосны орлого гэх мэт

**ТӨСВИЙН БАЙГУУЛЛАГЫН ӨӨРИЙН ОРЛОГО**

308.2 ▼ 8% 2017

Төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлого

**ТУСЛАМЖИЙН ОРЛОГО**

110.0 ▲ 45% 2017

Бусад улс болон олон улсын байгууллагаас өгөх тусламжийн орлого

Монгол Улсын татвар нь албан татвар, хураамж, төлбөрөөс бүрдэнэ. Татварын ерөнхий хуульд заасанчлан 13 төрлийн албан татвар, 9 төрлийн төлбөр, 4 төрлийн хураамж багтаж байна.

**Албан татвар**: Татвар төлөгчдийн орлого, эд хөрөнгө, бараа, ажил, үйлчилгээнээс хуулийн дагуу хариу төлбөргүйгээр авч байгаа татвар.

**Төлбөр**: Төрийн өмчийн байгалийн баялгийг ашиглуулсан болон бохирдуулсны төлөө авч буй татвар.

**Хураамж:** Төрийн байгууллагаас үйлчилгээ үзүүлсний төлөө авч байгаа татвар.

**Татварын бус орлого:** Төрийн болон орон нутгийн өмчийн эх үүсвэрээс орж ирэх ногдол ашиг, эд хөрөнгийг ашигласны төлбөр, түрээс, торгууль болон төсвийн байгууллагын туслах үйл ажиллагааны орлого, Засгийн газрын зээллэг, тусламж болон хууль тогтоомжийн дагуу төсөвт төвлөрүүлэх бусад орлогоос бүрдэнэ.

## ТАТВАРЫН УРАМШУУЛАЛ, ХӨНГӨЛӨЛТ, ЧӨЛӨӨЛӨЛТ

Татварын ерөнхий хуулийн дагуу татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг гагцхүү хуулиар эдлүүлдэг бөгөөд өнөөгийн байдлаар 258 гаруй төрлийн хөнгөлөлт, чөлөөлөлтийн заалтууд хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. 2018 онд нийт 686.0 тэрбум төгрөгийн татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэхээр байна.

| | |
|---|---|
| Нэмэгдсэн өртгийн албан татвар (НӨАТ) | 213.1 тэрбум |
| ААН-ийн орлогын албан татвар | 189.1 тэрбум |
| Хувь хүний орлогын албан татвар | 125.2 тэрбум |
| Онцгой албан татвар | 109.2 тэрбум |
| Гаалийн албан татвар | 49.4 тэрбум |

Татварын хөнгөлөлт үзүүлэх, татвараас чөлөөлөх хэлбэр

- ногдуулсан татварыг хорогдуулах;
- татварын хувь, хэмжээг бууруулах;
- тогтоосон доод хэмжээнд хүрээгүй орлого, эд хөрөнгө, бараа, ажил, үйлчилгээг татвараас чөлөөлөх;
- татвар төлөгчийг татвараас чөлөөлөх;
- татвар ногдох зүйлийн зохих хэсгийг татвараас чөлөөлөх;
- хууль тогтоомжид заасан бусад хөнгөлөлт.

### ТАТВАРЫН ЧӨЛӨӨЛӨЛТ

Татвар ногдох орлогыг хэсэгчлэн буюу бүрмөсөн бууруулахыг хэлнэ. Жишээлбэл, Хувь хүний орлогын албан татварын хуульд заасанаар хувь хүний тэтгэвэр, тэтгэмжийн болон нэмэгдсэн өртгийн албан татварын урамшууллын орлогыг албан татвараас чөлөөлдөг.

### ТАТВАРЫН ХӨНГӨЛӨЛТ

Ногдуулсан татварыг бууруулан тооцохыг хэлнэ. Жишээлбэл иргэдийн газар тариалангийн орлогод ногдуулсан татварыг 50%-иар хөнгөлөх буюу төлбөл зохих татварын 50%-ийг авдаг.

## НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН УРАМШУУЛАЛ

УИХ, Засгийн газраас эдийн засгийн өсөлтийг татварын бодлогоор дэмжих, татварын энгийн ойлгомжтой, тэгш шударга байх зарчмыг хангах, олон улсын жишигт нийцүүлэх чиглэлээр үе шаттай арга хэмжээ авч хэрэгжүүлсний нэг нь 2016 оны 1 сарын 1-нээс хэрэгжүүлсэн НӨАТ-ын тухай хуулийн шинэчилсэн найруулга юм. Тус хуулиар дараах хоёр төрлийн урамшуулал олгохоор өөрчлөлт орсон.

### ТАТВАРЫН 20% ХҮРТЭЛ БУЦААН ОЛГОЛТ

Татварын 20% хүртэл буцаан олголт авах болзол хангасан

35.5 тэрбум
620,409 татвар төлөгч

Үүнээс авсан татвар төлөгч 80.2%

35.1 тэрбум
497,650 татвар төлөгч

Шаардлагатай мэдээллийг бүрэн бүрдүүлээгүй тул үлдсэн 1.3% нь урамшууллаа авч чадаагүй байна.

### СУГАЛААНЫ ТОХИРЛООР УРАМШУУЛАЛ

| Шагнал | Иргэн |
|---|---|
| 500 сая | 1 иргэн |
| 100 сая | 5 иргэн |
| 20 сая | 16 иргэн |
| 4 сая | 224 иргэн |
| 500 мянга | 2,180 иргэн |
| 100 мянга | 22,017 иргэн |
| 20 мянга | 205,172 иргэн |

НӨАТ-ын сугалаанаас 229,615 иргэн нийт 9.6 тэрбум төгрөг хожсон.

## ХУВЬ ХҮНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ХӨНГӨЛӨЛТ, ЧӨЛӨӨЛӨЛТ

Татвар төлөгч иргэн та дараах татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг хувь хүний орлогын албан татвараас эдлэх эрхтэй. Үүнд:

Барьсан эсвэл худалдан авсан орон сууц
**3 сая төгрөг**
татварын чөлөөлөлт

Таны хүүхдийн их дээд, мэргэжлийн боловсрол, коллежийн
**СУРГАЛТЫН ТӨЛБӨРТ**
татварын хөнгөлөлт

Суралцаж байхдаа ажиллаж буй татвар төлөгчийн
**СУРГАЛТЫН ТӨЛБӨРТ**
татварын хөнгөлөлт

Цалингийн хэмжээнээс хамаарч жилдээ
**0-160 мянган төгрөг**
татварын хөнгөлөлт

Хувь хүний орлогын албан татварын тухай хуулиар жилийн албан татварт 84,000 төгрөгийн татварын хөнгөлөлт үзүүлдэг байсан бол 2018 оноос цалингийн орлогоос хамааран хөнгөлөлтийг ялгавартай тогтоосон. Ингэснээр бага цалин орлоготой хүмүүст ногдох бодит татварын хэмжээг бууруулах давуу талтай юм. Доор үзүүлсэн хүснэгтэд татварын хувь хэмжээ болон ногдуулсан татварын бодит хувь хэмжээ цалингийн орлогоос хамааран хэрхэн өөрчлөгдөж байгааг харуулав. Жишээлбэл, цалингийн орлого 300,000 байхад татварын хөнгөлөлт эдэлснээр ногдуулсан татвар 10% биш 5%-тай тэнцэхээр байна. Харин өндөр цалинтай буюу 3,500,000 төгрөгөөс дээш цалинтай бол татварын хөнгөлөлт эдлэхгүй тул ногдох татвар 10% хэвээр байна.

| Цалин | НДШ төлбөр (11 хувь) | Татвар ногдуулах орлого | Ногдуулах татвар (10 хувь) | Хөнгөлөлтийн хэмжээ | Төлөх татвар | ХХОАТ-ын бодит татварын хувь |
|---|---|---|---|---|---|---|
| **300,000** | 33,000 | **267,000** | 26,700 | **13,333** | 13,367 | **5.0%** |
| **800,000** | 88,000 | **712,000** | 71,200 | **11,667** | 59,533 | **8.4%** |
| **1,200,000** | 132,000 | **1,068,000** | 106,800 | **10,000** | 96,800 | **9.1%** |
| **1,800,000** | 198,000 | **1,602,000** | 160,200 | **8,333** | 151,867 | **9.5%** |
| **2,400,000** | 264,000 | **2,136,000** | 213,600 | **6,667** | 206,933 | **9.7%** |
| **3,000,000** | 264,000 | **2,736,000** | 273,600 | **5,000** | 268,600 | **9.8%** |
| **3,500,000** | 264,000 | **3,236,000** | 323,600 | **-** | 323,600 | **10.0%** |

### ТАТВАРЫН ТАЛААР ЗӨВЛӨГӨӨ, МЭДЭЭЛЭЛ АВАХ ЭХ ҮҮСВЭР

Харьяа дүүрэг, аймгийн Татварын ерөнхий газрын Олон нийттэй харилцах алба

**www.mta.mn** — Татварын ерөнхий газрын цахим хуудас

**tcc@mta.gov.mn** — Цахим шуудан илгээх эсвэл бичгээр хандаж болно

**1800 – 1288** — Мэргэжлийн зөвлөгөө авах

### МОНГОЛ УЛС ТАТВАРААС ЗАЙЛСХИЙДЭГ БУСИЙН “ХАР ЖАГСААЛТ”-ААС ГАРЛАА

Монгол Улс ЭЗХАХБ (OECD)–ын санаачлан хэрэгжүүлдэг татварын ил тод байдал, мэдээлэл солилцооны хөтөлбөрүүдэд гишүүнээр элссэн. Олон улсын татварын зарчмуудыг өөрийн оронд нэвтрүүлснээр татвараас зайлсхийх, зугтах явдал багасч, хуулийн дагуу шудрагаар татвараа тайлагнах, төлөх явдал нэмэгдэх тул дунд хугацаанд төсвийн орлогыг нэмэгдүүлэх эерэг нөлөөтэй юм. Энэхүү амлалтын дараагаар татварын зорилгоор хамтарч ажилладаггүй орнуудын жагсаалт буюу “Хар жагсаалт”-аас Монгол Улсыг албан ёсоор хассанаа Европын Холбоо мэдэгдсэн юм.

# БҮЛЭГ 3. ТӨСВИЙН ЗАРЛАГА

## 2018 ОНЫ ТӨСВИЙН НИЙТ ЗАРЛАГА

Монгол Улсын 2018 оны төсвийн нийт зарлагыг 9,651.5 тэрбум төгрөгөөр баталсан нь өмнөх оноос 5.4%-иар нэмэгдсэн байна. ОУВС-тай байгуулсан “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-т хамрагдсантай холбоотойгоор төрөөс иргэдэд хүргэх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, иргэдийн нийгмийн хамгааллыг бэхжүүлэх чиглэлээр урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг нэмэгдүүлж, тэвчиж болох зардлыг өсгөхгүй байхаар төсвийн зарлагыг баталсан.

**ЭДИЙН ЗАСГИЙН АНГИЛЛААР (2016-2018 он, тэрбум төгрөг)**




### УРСГАЛ ЗАРДАЛ, ТҮҮНИЙ ӨСӨЛТӨНД НӨЛӨӨЛСӨН ХҮЧИН ЗҮЙЛС

Нэн шаардлагатай урсгал зардлын өсөлт 637.4 тэрбум байсан бөгөөд бусад үйл ажиллагааны урсгал зардлын хэмнэлтээс 183.1 тэрбум төгрөгийг санхүүжүүлэхээр тооцсон. 2018 онд шаардлагатай урсгал зардлын өсөлт 454.3 тэрбум төгрөгөөр нэмэгдэхэд дараах хүчин зүйлс нөлөөлсөн байна.

| Үйл ажиллагаа | Тэрбум төгрөг | Үйл ажиллагаа | Тэрбум төгрөг |
|---|---|---|---|
| Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх | 137.4 | Эрүүл мэндийн салбар | 39.4 |
| Тэтгэвэр авагчдын тооны өсөлт | 50.3 | ЭМД-ын тусламж үйлчилгээ, хамрах хүрээг нэмэгдүүлэх | 13.0 |
| Малчны тэтгэврийн насыг 5 жилээр урагшлуулах | 44.6 | Агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээ | 13.0 |
| Цалинтай ээж хөтөлбөр | 72.8 | Хүнс, ХАА-н салбар | 8.6 |
| Хүнсний талон, нийгмийн халамжийн бусад хөтөлбөр | 71.8 | Гадаад харилцаа, батлан хамгаалах салбар | 18.1 |
| Сахилга хариуцлага, ажлын үр дүнгийн урамшуулал | 56.2 | Хилийн боомт, гал унтраах анги, аврах бүлгүүд байгуулах | 11.1 |
| Орон нутгийн төсвийн өөрийн удирдлагыг сайжруулах | 43.1 | Зардал бууруулах арга хэмжээ | -183.1 |
| БСШУС-ын салбар | 58.0 | | |
| **Нийт урсгал зардлын төсвийн өөрчлөлт** | | | **454.3** |

## УРСГАЛ ЗАРДЛЫН БҮТЭЦ

| Ангилал | Хувь | Дүн | Өөрчлөлт | Тайлбар |
|---|---|---|---|---|
| Цалин, хөлс | 24.1% | 1,797.1 | ▲1.7% | Нийт 182,731 төрийн албан хаагчдын цалингийн сан |
| Бараа, Үйлчилгээ | 19.6% | 1,460.4 | ▲10.4% | Өдөр тутмын бичиг хэрэг, харилцаа холбоо, түлш халаалт ашиглалтын зардал |
| Зээлийн төлбөр | 15.4% | 1,150.7 | ▼0.5% | Төсвийн алдагдлыг нөхөж буй Засгийн газрын зээлийн хүүний төлбөр |
| Татаас | 3.1% | 233.9 | ▲17.4% | Төрийн болон хувийн ААН-ийг дэмжихэд олгож буй мөнгөн хөрөнгө |
| Урсгал шилжүүлэг | 37.7% | 2,813.8 | ▲10.1% | Хууль тогтоомж, бусад шийдвэрээр ЗГ-аас олгох дэмжлэг, тусламж |

### ТӨРИЙН АЛБАН ХААГЧ 182,731

| Хувь | Тоо | Салбар |
|---|---|---|
| 32% | 58,352 | Төрийн үйлчилгээ |
| 24% | 43,382 | Боловсрол |
| 19% | 34,994 | Төрийн тусгай |
| 12% | 20,845 | Төрийн захиргаа |
| 11% | 20,413 | Эрүүл мэнд |
| 3% | 4,745 | Бусад |

### УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ

| Төрөл | Дүн |
|---|---|
| НДС тэтгэвэр, тэтгэмж | 1,789.1 тэрбум төгрөг |
| Халамжийн тэтгэвэр, тэтгэмж | 646.0 тэрбум төгрөг |
| Тэтгэвэрт гарахад олгох тэтгэмж | 76.9 тэрбум төгрөг |
| Үр дүнгийн урамшуулал | 55.7 тэрбум төгрөг |
| Орон нутагт ажилласны тэтгэмж | 41.8 тэрбум төгрөг |
| Үдийн цай хөтөлбөрт | 32.5 тэрбум төгрөг |
| Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан | 42.3 тэрбум төгрөг |
| Бусад | 129.6 тэрбум төгрөг |

### ТАТААС

| Салбар | Дүн |
|---|---|
| Сургууль цэцэрлэг | 55.2 тэрбум төгрөг |
| Санхүүгийн зах зээлийн зохицуулалт | 3.6 тэрбум төгрөг |
| Нийтийн тээвэр | 38.2 тэрбум төгрөг |
| Эмийн үнийн хөнгөлөлт | 47.5 тэрбум төгрөг |
| Эрчим хүчний салбар | 25.4 тэрбум төгрөг |
| Шуудан, харилцаа холбоо | 8.4 тэрбум төгрөг |
| ХАА-н салбар | 54.1 тэрбум төгрөг |
| Бусад | 1.4 тэрбум төгрөг |

## ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ, ТОМООХОН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТУУД

| Ангилал | Дүн | Өөрчлөлт | Тайлбар |
|---|---|---|---|
| Барилга байгууламж | 1,049.8 | ▲0.8% | Шинээр барилга байгууламж барих, өргөтгөл хийх болон худалдан авахтай холбоотой зардал |
| Их засвар | 72.2 | ▼7.4% | Төрийн болон орон нутгийн өмчийн барилга, тоног төхөөрөмжийг их засварт оруулахад шаардагдах зардал |
| Тоног төхөөрөмж | 292.6 | ▲193.6% | Хөрөнгө оруулалтын шинж чанартай тоног төхөөрөмж худалдан авах төсөл, арга хэмжээнд зарцуулах зардал |
| Стратегийн нөөц хөрөнгө | 31.2 | ▼14.1% | Үндэсний аюулгүй байдлыг хангах, гамшиг, дайн зэрэг онцгой байдалд ашиглахаар нөөцлөх бараа материалын зардал |
| Бусад хөрөнгө | 482.8 | ▼13.6% | Тусгайлан нэр заагдаж ангилагдсанаас бусад хөрөнгийн зардалд хамаарах зардал |

- Улсын төсвөөс 111 цэцэрлэг, 79 сургууль барихад **201.8 тэрбум** төгрөг
- Шинээр 37 эмнэлэг, 2 эмнэлгийн өргөтгөл барихад **138.2 тэрбум,** тусгай тоног төхөөрөмж **29.8 тэрбум** төгрөг
- Аймгийн төвүүдийг Улаанбаатар хоттой холбох **784.0 км** авто зам
- Төв цэвэрлэх байгууламжийг шинэчлэхэд **10.0 тэрбум** төгрөг
- Зүүн дөрвөн зам, Замын цагдаагийн уулзварын гүүрэн гарцын барилгад **17.7 тэрбум** төгрөг
- Нийслэл, хөдөө орон нутагт 18 гүүр, **19.8 тэрбум** төгрөг
- Улаанбаатар - Шинэ нисэх онгоцны буудлын хурдны авто зам **32.3 км** барихад **57.5 тэрбум** төгрөг
- Шинэ нисэх онгоцны буудлын барилгыг ашиглалтанд оруулахад **111.9 тэрбум** төгрөг
- Нийслэл хот, аймгийн төвүүдийн дулааны цахилгааны станцын хүчин чадлыг нэмэгдүүлэхэд **37.8 тэрбум** төгрөг
- Улаанбаатар - Мандалговь хүртэл **255 км** урт цахилгаан дамжуулах агаарын шугамын ажилд **58.8 тэрбум** төгрөг
- Эрчим хүчний найдвартай хэрэглээг хангахад **37.6 тэрбум** төгрөг

## УЛСЫН ТӨСВӨӨР САНХҮҮЖИХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ




**БОЛОВСРОЛ**
- Цэцэрлэг
- Сургууль
- Дотуур байр

**ЭРҮҮЛ МЭНД**
- Эмнэлэг

**СОЁЛ УРЛАГ**
- Соёлын төв, театр
- Номын сан
- Спорт

**ТОХИЖИЛТ, ГЭРЭЛТҮҮЛЭГ**
- Цэцэрлэгт хүрээлэн
- Тохижилт
- Гэрэлтүүлэг




**ДЭД БҮТЭЦ**
- Цахилгаан
- Дулааны шугам
- Холболт
- Их засвар
- Зам, гүүр

**ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ, БУСАД**
- Төрийн үйлчилгээ
- Нийгмийн хамгаалал
- Орон сууц засвар
- Тоног төхөөрөмж
- Бусад

# ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧДЫН 2018 ОНЫ ТӨСӨВ

Монгол Улсын төсөвт хамаарах 31 төсвийн ерөнхийлөн захирагчид 7,710.8 тэрбум төгрөг хуваарилсан нь өмнөх жилтэй харьцуулахад 3.9%-иар өссөн байна.

ТӨСВИЙН БҮТЭЦ (тэрбум төгрөгөөр)

| ТЕЗ | Урсгал зардал | Хөрөнгийн зардал | Гадны зээл, тусламж | Эргэж төлөгдөх цэвэр зээл | НИЙТ | 2017 оноос |
|---|---|---|---|---|---|---|
| Сангийн сайд | 1,540.1 | 32.8 | 152.2 | 64.5 | 1,789.6 | ▲ 11.1% |
| БСШУС-ын сайд | 1,136.4 | 262.8 | 136.3 | 96.8 | 1,632.3 | ▲ 23.4% |
| ХНХ-ын сайд | 1,201.9 | 17.3 | 25.6 | 22.9 | 1,267.7 | ▲ 10.5% |
| Эрүүл мэндийн сайд | 633.0 | 60.8 | 72.6 | | 766.3 | ▲ 10.3% |
| ХЗДХ-ийн сайд | 428.2 | 37.4 | 11.4 | -20.6 | 456.4 | ▲ 2.6% |
| Зам, тээврийн хөгжлийн сайд | 9.2 | 80.8 | 294.5 | | 384.5 | ▼ 41.1% |
| Батлан хамгаалахын сайд | 233.5 | 3.6 | | | 237.1 | ▲ 3.4% |
| Монгол Улсын Ерөнхий сайд | 98.1 | 94.5 | 10.8 | | 203.3 | ▼ 26.0% |
| Эрчим хүчний сайд | 19.5 | 37.7 | 103.9 | | 161.0 | ▼ 32.2% |
| ХХААХҮ-ийн сайд | 107.6 | 50.2 | 11.0 | -17.7 | 151.1 | ▼ 32.9% |
| Барилга, хот байгуулалтын сайд | 15.1 | 80.3 | 41.8 | | 137.2 | ▲ 24.2% |
| Монгол Улсын Шадар сайд | 113.2 | 14.1 | 9.4 | | 136.7 | ▲ 17.0% |
| Байгаль орчин, аялал жуулчлалын сайд | 57.4 | 20.7 | 10.1 | | 88.2 | ▲ 27.9% |
| Гадаад харилцааны сайд | 69.9 | 1.8 | | | 71.7 | ▲ 9.7% |
| Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга | 48.6 | | | | 48.6 | ▲ 4.0% |
| Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга | 13.6 | 11.9 | 8.0 | | 33.5 | ▲ 38.6% |
| Монгол Улсын Их Хурлын дарга | 28.5 | 1.9 | 2.7 | | 33.1 | ▼ 2.9% |
| Улсын ерөнхий прокурор | 28.5 | 0.5 | 0.3 | | 29.2 | ▲ 9.4% |
| Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд | 9.1 | 17.3 | | | 26.4 | ▼ 4.0% |
| Авлигатай тэмцэх газрын дарга | 14.6 | 0.2 | | | 14.8 | ▲ 42.7% |
| Монгол Улсын Ерөнхий аудитор | 10.9 | 0.5 | 0.1 | | 11.5 | ▲ 19.7% |
| Үндэсний статистикийн хорооны дарга | 9.5 | | | | 9.5 | ▲ 14.3% |
| Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга | 4.5 | 0.8 | | | 5.2 | ▲ 14.9% |
| Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч | 4.0 | | | | 4.0 | ▼ 2.1% |
| Санхүүгийн зохицуулах хорооны дарга | 3.8 | | | | 3.8 | ▲ 50.0% |
| Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга | 2.1 | | | | 2.1 | ▲ 2.2% |
| Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дарга | 1.7 | 0.3 | | | 2.0 | ▲ 27.5% |
| Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга | 1.1 | | | | 1.1 | ▲ 41.6% |
| Сонгуулийн ерөнхий хорооны дарга | 1.1 | | | | 1.1 | ▼ 92.8% |
| Төрийн албаны зөвлөлийн дарга | 0.7 | | | | 0.7 | ▲ 0.02% |
| Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын дарга | 0.6 | | | | 0.6 | ▲ 14.9% |
| **НИЙТ ДҮН** | **5,846.1** | **828.2** | **890.6** | **145.9** | **7,710.8** | |

## ЗАСГИЙН ГАЗРЫН ГАДААД ЗЭЭЛ, ТУСЛАМЖ

Монгол Улсын Засгийн газрын гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр 2018 оны төсвийн жилд нийт 127 төсөл, арга хэмжээнд 945.9 тэрбум төгрөгийн төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ. Үүний 835.9 тэрбум төгрөг нь гадаад зээлээр, 110.0 тэрбум төгрөг нь буцалтгүй тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлнэ. Хамгийн их буюу 25 төсөл авто зам, дэд бүтцийн салбарт хэрэгжих бол 16 төсөл хот төлөвлөлт, 14 төсөл боловсрол, 13 төсөл эрчим хүч, 11 төсөл эрүүл мэнд, 48 төсөл бусад салбарт тус тус хэрэгжихээр байна.




Бусад хөгжлийн түншлэгчийн санхүүжилтээр хэрэгждэг:

- Кувейтын Засгийн газар - 1
- Бельгийн Вант Улсын Засгийн газар - 1
- БНФУ-ын Засгийн газар - 1
- БНЭУ-ын Засгийн газар - 2
- Хөдөө аж ахуйг хөгжүүлэх сан - 1
- Европын хөрөнгө оруулалтын банк - 1

Тухайлбал, Яармагийн шинэ гүүр барих, хуучин гүүрийг засварлах, Улаанбаатар-Хөшигтийн хөндийн шинэ нисэх онгоцны буудлын хурдны зам барих, Баянхонгор-Байдрагийн гүүр чиглэлийн 129.4 км автозам барих, Тосонцэнгэл-Улиастай чиглэлийн 114 км авто зам барих, Бүс нутгийн логистикийн төвийг хөгжүүлэх, Замын-Үүдийн дэд бүтцийг сайжруулах, Орон сууцны хороолол, дэд бүтэц зэрэг төслүүдийг 2018 онд бүрэн дуусгаж, ашиглалтад оруулна.

Мөн Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламж, Арвайхээр, Даланзадгад, Цэцэрлэг, Сайншанд аймгийн төвүүдэд бохир ус цэвэрлэх байгууламжийг барих ажлыг эхлүүлж, Улаанбаатар хотын шинэ олон улсын нисэх онгоцны буудлыг үргэлжлүүлэн барих, Эрүүл мэндийн салбар хөгжил хөтөлбөр-4 зэрэг томоохон төсөл, арга хэмжээнүүдийг хэрэгжүүлнэ.

## ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР

Засгийн газрын өрийн үлдэгдэл 2017 оны жилийн эцсийн байдлаар 22,751.6 тэрбум төгрөгт хүрч өнөөгийн үнэ цэнээр дотоодын нийт бүтээгдэхүүний 74.4%-тай тэнцэж байсан бол 2018 онд 22,642.7 тэрбум буюу өнөөгийн үнэ цэнээр дотоодын нийт бүтээгдэхүүний 63.4%-д хүрэхээр байна.



* - Хүлээгдэж буй гүйцэтгэл

| ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН БҮТЭЦ | 2015.12.31 | 2016.12.31 | 2017.12.31 | 2018* |
|---|---|---|---|---|
| I. Засгийн газрын дотоод өр | 3,800.0 | 6,464.9 | 4,230.1 | 3,222.7 |
| 1.1 Үнэт цаас | 3,333.2 | 5,488.8 | 3,461.9 | 2,221.7 |
| 1.2 Өрийн бичиг/вексель | 164.3 | 307.2 | 0.0 | 0.0 |
| 1.3 Концесс | 261.0 | 668.9 | 768.2 | 1,001.0 |
| II. Засгийн газрын гадаад өр | 7,881.2 | 12,363.8 | 16,857.8 | 17,925.8 |
| 2.1 Үнэт цаас | 3,315.8 | 5,380.5 | 7,701.6 | 6,907.8 |
| 2.2 Зээл | 4,565.4 | 6,983.3 | 9,156.2 | 11,018.0 |
| III. Засгийн газрын өрийн баталгаатай зээллэг | 2,743.5 | 3,451.5 | 1,663.7 | 1,494.2 |
| 3.1 Засгийн газрын өрийн баталгаа | 2,743.5 | 3,451.5 | 1,663.7 | 1,494.2 |
| ЗАСГИЙН ГАЗРЫН НИЙТ ӨР (I+II+III) | 14,424.7 | 22,280.1 | 22,751.6 | 22,642.7 |
| ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР (ӨҮЦ) | 12,124.2 | 18,861.0 | 20,212.1 | 19,406.0 |
| Хуулиар тогтоосон өрийн хязгаар | 58.3% | 88.0% | 85.0% | 80.0% |
| Засгийн газрын өр (ӨҮЦ) / ДНБ - ХБГ | 52.4% | 78.8% | 74.4% | 63.4% |

** - Хүлээгдэж буй гүйцэтгэл*

Монгол Улсын 2017 оны нийт өрийн бүтцийн дийлэнх буюу 74.1%-ийг Засгийн газрын гадаад өр, 18.6%-ийг дотоод өр, 7.3%-ийг Засгийн газрын өрийн баталгаа эзэлж байна.

Засгийн газрын 2017 оны өрийн үлдэгдлийг өрийн бүтэц бүрээр дараагийн хуудсанд дэлгэрэнгүй харуулсан болно.

## ЗАСГИЙН ГАЗРЫН ДОТООД ӨР (2017 оны эцэст 4,230.1 тэрбум төгрөг )

### ЗАСГИЙН ГАЗРЫН ДОТООД ҮНЭТ ЦААС

Санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх, Засгийн газрын мөнгөн хөрөнгийн удирдлагыг сайжруулах, улсын төсвийн улирлын чанартай орлого, зарлагын зөрүүг богино хугацаанд санхүүжүүлэхэд Засгийн газрын дотоод үнэт цаас чухал үүрэгтэй юм.

**ДОТООД ҮНЭТ ЦААСНЫ ӨРИЙГ БОДИТОЙГООР БУУРУУЛАВ**

Хөрөнгө өр төлбөрийн оновчтой удирдлагыг хэрэгжүүлэн 750 тэрбум төгрөгийн үнэт цаасыг хуваарийн дагуу төлж, 370 тэрбум төгрөгийн үнэт цаасыг хугацаанаас нь өмнө буцаан худалдан авснаар Засгийн газрын дотоод үнэт цаасны өрийн хэмжээ 2017 оны эцэст 25%-иар буурсан.

### БАРИХ-ШИЛЖҮҮЛЭХ НӨХЦӨЛТЭЙ КОНЦЕСС

Улсын болон орон нутгийн төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй концессын гэрээгээр хэрэгжиж буй төсөл арга хэмжээний гүйцэтгэлийг үндэслэн Засгийн газрын өрд бүртгэдэг. Барих-шилжүүлэх нөхцөлтэй концессын гэрээ гэдэг нь концессын гэрээгээр хэрэгжих төсөл арга хэмжээг концесс эзэмшигч аж ахуйн нэгж, хуулийн этгээд өөрийн болон өөрийн боломжоор олсон хөрөнгөөр барьж ашиглалтад оруулан, төрийн болон орон нутгийн өмчид шилжүүлэх бөгөөд төлбөрийг гэрээнд заасны дагуу төрийн болон орон нутгийн төсвөөс төлөх нөхцөлтэй гэрээ юм.

**ДОТООД ҮНЭТ ЦААСНЫ ҮЛДЭГДЭЛ 3,461.9 тэрбум төгрөг**

- **4000 айлын орон сууц хөтөлбөр** — **2.0** тэрбум төгрөг
- **Сайн малчин хөтөлбөр** — **1.7** тэрбум төгрөг
- **Сайн хувьцаа арга хэмжээ** — **374.0** тэрбум төгрөг
- **Хүний хөгжил сан** — **218.4** тэрбум төгрөг
- **Төсвийн алдагдал нөхөх** — **2,865.8** тэрбум төгрөг

**КОНЦЕССЫН ҮЛДЭГДЭЛ 768.2 тэрбум төгрөг**

- **Боловсролын төсөл** — **32.2** тэрбум төгрөг
- **Зам тээврийн төсөл** — **589.5** тэрбум төгрөг
- **Эрүүл мэндийн төсөл** — **8.7** тэрбум төгрөг
- **Эрчим хүчний төсөл** — **133.8** тэрбум төгрөг
- **Бусад төсөл** — **4.0** тэрбум төгрөг

## ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН БАТАЛГАА (2017 оны эцэст 1,663.7 тэрбум төгрөг)

Засгийн газрын өрийн баталгаа гэдэг нь баталгаа гаргуулагч аж ахуйн нэгж, байгууллага төлбөрийн үүргээ гүйцэтгэж чадахгүй болсон тохиолдолд төлбөрийг баталгаа гаргуулагчийн өмнөөс төлж барагдуулахаар Засгийн газрын хүлээсэн үүргийг хэлнэ. Засгийн газар аж ахуйн нэгж, хуулийн этгээдийн гадаад болон дотоодын зах зээлээс хийж буй зээллэгэд баталгаа гаргаж болох бөгөөд энэ нь тухайн байгууллагын үйл ажиллагааг дэмжих, бага хүүгийн зардалтай хямд эх үүсвэрийг босгоход туслах зорилготой юм.



**ҮНЭТ ЦААСНЫ БАТАЛГАА**
**Үлдэгдэл:**
**399.3 сая ам.доллар**
**969.2 тэрбум төгрөг**

**ЗЭЭЛИЙН БАТАЛГАА**
**Үлдэгдэл:**
**286.7 сая ам.доллар**
**694.4 тэрбум төгрөг**

## ЗАСГИЙН ГАЗРЫН ГАДААД ӨР (2017 оны эцэст 16,857.8 тэрбум төгрөг)

Манай орны хувьд олон улсаас зээл авах, гадаадын санхүүгийн зах зээл дээр үнэт цаас бонд гаргах замаар эх үүсвэр татан төвлөрүүлж байна.

### ЗАСГИЙН ГАЗРЫН ГАДААД ҮНЭТ ЦААС

Төсөл хөтөлбөр болон өрийг санхүүжүүлэх зорилгоор олон улсын зах зээлд арилжаалсан Монгол Улсын Засгийн газрын үнэт цаасыг хэлнэ.

**ЧИНГИС 500 БОНДЫН ӨРИЙГ ДАРЛАА**

Таван жилийн хугацаатай “Чингис бонд”-ын өрийг хугацаанд нь төсөвт хүндрэл учруулахгүйгээр төлсөн нь хөрөнгө оруулагчид болон гадны зах зээлд эерэг “мессеж” болсон.

Засгийн газрын гадаад үнэт цаасны үлдэгдэл 2017 оны эцэст **7,701.6** тэрбум төгрөг байв.

### ЗАСГИЙН ГАЗРЫН ГАДААД ЗЭЭЛ

Олон талт болон хоёр талт зээлдүүлэгчдээс авч буй хөнгөлөлттэй нөхцөлтэй зээл, тусламж, техник туслалцааг хэлнэ. Засгийн газрын гадаад зээлийн үлдэгдэл 2017 оны эцэст **9,156.2** тэрбум төгрөг байв.

**Тэргүүлэх 5 зээлдүүлэгч, зээлийн дүнгээр (тэрбум төгрөг)**




Гаргасан он: 2012.12.05
Хугацаа: 10 жил
Жилийн хүү: 5.125%
Нийт: 1000 сая ам.доллар
**Үлдэгдэл:**
**1000.0 сая ам.доллар**
**2,427.1 тэрбум төгрөг**

Гаргасан он: 2015.06.30
Хугацаа: 3 жил
Жилийн хүү: 7.5%
Нийт: 1000 сая юань
**Үлдэгдэл:**
**145.9 сая ам.доллар**
**354.2 тэрбум төгрөг**

Гаргасан он: 2017.10.26
Хугацаа: 5 жил
Жилийн хүү: 5.625%
Нийт: 800 сая ам.доллар
**Үлдэгдэл:**
**800.0 сая ам.доллар**
**1,941.7 тэрбум төгрөг**




Гаргасан он: 2012.12.05
Хугацаа: 5 жил
Жилийн хүү: 4.125%
Нийт: 500 сая ам.доллар
**Үлдэгдэл:**
**127.2 сая ам.доллар**
**308.8 тэрбум төгрөг**

Гаргасан он: 2016.04.06
Хугацаа: 5 жил
Жилийн хүү: 10.875%
Нийт: 500 сая ам.доллар
**Үлдэгдэл:**
**500.0 сая ам.доллар**
**1,213.6 тэрбум төгрөг**

Гаргасан он: 2017.03.09
Хугацаа: 7 жил
Жилийн хүү: 8.75%
Нийт: 600 сая ам.доллар
**Үлдэгдэл:**
**600.0 сая ам.доллар**
**1,456.3 тэрбум төгрөг**

## ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Засгийн газрын өрийн үйлчилгээний зардалд хүүгийн зардал болон гэрээнд заасан шимтгэл хураамжийн зардал ордог. Засгийн газрын зүгээс өндөр хүүтэй дотоод бонд гаргалтыг багасгаж, төрийн сангийн мөнгөн хөрөнгийн удирдлагыг сайжруулах, гадаадын хямд өртөгтэй эх үүсвэрийг ашиглах замаар жилээс жилд хурдацтай өсч буй хүүгийн зардлыг бууруулах бодлого баримталж байгаа бөгөөд хүүгийн зардалд 2018 онд 1,150.7 тэрбум төгрөг төсөвлөсөн нь 2017 оноос 4.4 тэрбум төгрөгөөр бага байна.




Жилийн 16-18% хүрээд байсан Засгийн газрын дотоод үнэт цаасны хүүг хоёр дахин бууруулж Засгийн газрын дотоод үнэт цаасны суурь хүүг 8-9% болох нөхцлийг бүрдүүлж дотоодын үнэт цаасыг арилжаалсан. Энэ нь сүүлийн дөрвөн жилийн Засгийн газрын дотоод үнэт цаасны хамгийн бага хүүгийн түвшинд хүрсэн үзүүлэлт болж цаашид санхүүгийн зах зээл дэх хүүгийн түвшинг бууруулахад бодит нөлөө үзүүлсэн юм.




Хүүгийн зардлын хэмжээ нь нийгэм, эдийн засгийн чухал арга хэмжээнд зарцуулах зардлаас хэд дахин их байна. Тухайлбал, хүрээлэн буй орчин хамгааллаас 10 дахин, эрүүл мэндийн салбарын нийт зардлаас 1.4 дахин их байна. Өөрөөр хэлбэл, хэрэв Засгийн газрын зээлийн үйлчилгээнд мөнгө төлдөггүй байсан бол энэхүү эх үүсвэрийг өөр хэрэгтэй зүйлд зарцуулах бүрэн боломжтой байсан юм.

# БҮЛЭГ 4. 2018 ОНЫ ТӨСВИЙН ОНЦЛОГ

## 2018 ОНЫ ТӨСВИЙН ЗОРИЛТ

Монгол Улсын 2018 оны төсөв бол төсвийн сахилга батыг чангатгаж, төсвийн үргүй зардлыг багасгах, өрийн дарамт зээлийн хүүгийн зардлыг бууруулахын зэрэгцээ нийгмийн тулгамдсан асуудлуудыг дорвитойгоор шийдсэн төсөв болсон.

1. Ил тод нээлттэй байдлыг бий болгох замаар төсвийн орлогыг нэмэгдүүлнэ.
2. Өрийн дарамт, зээлийн хүүгийн зардлыг бууруулахад чиглэсэн дорвитой алхам хийнэ.
3. Хүүхэд бүрт хүртээмжтэй сургууль, цэцэрлэгийн орчин нөхцлийг бүрдүүлнэ.
4. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарт чиглэсэн санхүүжилтийг нэвтрүүлнэ.
5. Оюутны сургалтын төлбөрийн дарамтыг чөлөөлнө.
6. Орон нутгийн төсөв, санхүүгийн бие даасан байдлыг нэмэгдүүлнэ.
7. Цалинтай ээж хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
8. Тэтгэвэр, тэтгэмжийг инфляцийн түвшинтэй уялдуулан нэмэгдүүлнэ.
9. Малчдын тэтгэвэрт гарах насыг 5 жилээр урагшлуулна.
10. Нийслэлийн төв цэвэрлэх байгууламжийг бүрэн шинэчлэх ажлыг эхлүүлнэ.
11. Төсөв хэлэлцэх, батлах үйл явцыг хариуцлагатай болгоно.
12. Төсвийн сахилга хариуцлагыг чанд мөрдүүлнэ.

### ТӨСВИЙН ЗАРЛАГА САЛБАРААР
(тэрбум төгрөг)

| Салбар | Хувь | Дүн | 2017 оноос |
|---|---|---|---|
| Төрийн нийтлэг үйл ажиллагаа | 32.8% | 3,227.8 | ▲ 0.9% 2017 оноос |
| Нийгмийн хамгаалал | 26.0% | 2,556.2 | ▲ 12.9% 2017 оноос |
| Боловсрол | 14.5% | 1,428.1 | ▲ 17.4% 2017 оноос |
| Батлан хамгаалах, нийгмийн хэв журам | 9.1% | 892.2 | ▲ 3.2% 2017 оноос |
| Эрүүл мэнд | 8.4% | 825.7 | ▲ 5.6% 2017 оноос |
| Эдийн засгийн үйл ажиллагаа | 6.5% | 641.9 | ▼ 19.4% 2017 оноос |
| Спорт, соёл урлаг аялал жуулчлал | 1.5% | 149.2 | ▲ 36.0% 2017 он |
| Хүрээлэн буй орчин хамгаалал | 1.1% | 109.0 | ▲ 30.5% 2017 он |

9,830.1*

*Нийгмийн даатгалын шилжүүлэг 178.6 тэрбум төгрөг орсон тул нийт зардал 9,651.5-аас их байна.

## ТӨРИЙН НИЙТЛЭГ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Ерөнхийлөгч, хууль тогтоох, гүйцэтгэх засаглал, орон нутгийн удирдлагын байгууллагын зардлаас гадна төрийн нийтлэг үйл ажиллагаа явуулж байгаа Төрийн аудитын байгууллага, Үндэсний статистикийн хороо, Мэргэжлийн хяналт гэх мэт бусад төрийн байгууллагуудын үйл ажиллагаа хамаарна.

Түүнчлэн, гадаадын зээл тусламжаар хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрүүдийн зардал болон Засгийн газрын зээлийн хүүгийн төлбөр тус хөтөлбөрт хамаарна.

**ТӨСВИЙН 2018 ОНД ОНЦЛОГ**

- Зээлийн үйлчилгээний төлбөрийг бууруулна.
- Орон нутгийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.
- Ипотекийн зээлийн хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

**3,227.8 тэрбум**

| | 2018 (тэрбум) | 2017 оноос |
|---|---|---|
| Төлөвлөлт, санхүү, төсвийн харилцаа | 385.0 | ▼ 7.8% |
| Гадаад харилцаа | 71.7 | ▲ 11.0% |
| Ерөнхийлөгч, хууль тогтоох, гүйцэтгэх засаглал, орон нутгийн удирдлага | 426.1 | ▲ 3.9% |
| Төрийн нийтлэг бусад үйлчилгээ, үйл ажиллагаа | 165.3 | ▲ 10.4% |
| Засаг захиргааны түвшин хоорондын шилжүүлэг | 77.9 | ▲ 97.0% |
| Гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлэх төсөл хөтөлбөр | 950.9 | ▼ 1.1% |
| Зээлийн үйлчилгээний төлбөр | 1,150.7 | ▼ 0.5% |




| Урсгал зардал | 1,834.8 |
|---|---|
| - Цалин, НДШ | 295.5 |
| - Хүү | 1,150.7 |
| - Бараа үйлчилгээ | 352.9 |
| - Татаас | 3.6 |
| - Урсгал шилжүүлэг | 32.1 |

** Гадаад зээл, тусламж болон зээлийн үйлчилгээний зардлыг 3-р бүлгээс үзнэ үү.*

### ЗАРДЛЫН ӨӨРЧЛӨЛТ

**Ерөнхий төлөвлөлт, санхүү төсвийн харилцаа**

- **9.0** тэрбум — Ипотекийн зээл 120.0 тэрбум төгрөг болж өссөн
- **38.3** тэрбум — Орон нутгийн хөгжлийн сангийн зардлыг нэмэгдүүлэх
- **45.0** тэрбум — “Сайн малчин”, 4,000 айл, 100,000 айл хөтөлбөрийг зогсоосонтой холбоотой зээлийн эргэн төлөлт
- **6.4** тэрбум — Монголын цахилгаан холбоо хувьцаат компаний 40%-ийг буцаан авах

**Гадаад харилцаа**

- **2.9** тэрбум — Гадаад улс дахь дипломат төлөөлөгчийн ажилтны хүүхдийг цэцэрлэгт хамруулах
- **1.6** тэрбум — Хятад улсын Шанхай, Эрээн, Манжуур хот, Япон улсын Осака хотод консулын газар байгуулах
- **1.9** тэрбум — Далайд гарцгүй орнуудын олон улсын судалгааны төв, МСК-ийн усан хангамжийг сайжруулах төслийн ажлын албаны зардал
- **1.2** тэрбум — МСК болон Монгол Улсын Засгийн газар хооронд үзэглэсэн Компакт гэрээ 2-ын Монголын тал хариуцах зардал

**Төрийн нийтлэг бусад үйлчилгээ, үйл ажиллагаа**

- **2.1** тэрбум — Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа, Хүн ам, орон сууцны улсын тооллого 2020 оны бэлтгэл
- **1.5** тэрбум — Гашуунсухайт боомт, шинэ нисэх буудлын мэргэжлийн хяналтын зардал
- **-14.6** тэрбум — Сонгууль зохион байгуулах зардлын бууралт
- **4.5** тэрбум — Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилт

## НИЙГМИЙН ХАМГААЛАЛ

Нийгмийн хамгааллын бодлого нь ядуурлыг бууруулах, эрсдэлд өртөмтгий бүлэг болох хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, эмэгтэйчүүд, ахмад настныг хамгаалах, нийгэмшүүлэхэд чиглэсэн нийгмийн халамж, хамгааллын хөтөлбөр, түүнчлэн хөдөлмөр эрхэлж буй иргэдийг ажилгүй болох, хөдөлмөрийн чадвараа алдах, өндөр наслахтай холбоотойгоор ирээдүйд бий болох эрсдэлээс хамгаалах зорилгоор нийгмийн даатгалын үйлчилгээгээр хэрэгжинэ.

**ТӨСВИЙН 2018 ОНД ОНЦЛОГ**

- “Цалинтай ээж” хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлнэ.
- Нэн ядуу, эмзэг бүлэгт чиглэсэн нийгмийн халамжийг нэмэгдүүлнэ.
- Тэтгэврийн хэмжээг инфляцтай уялдуулан индексжүүлж нэмэгдүүлнэ.
- Малчны тэтгэвэрт гарах насыг 5 жилээр урагшлуулна.
- “Насны хишиг” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

Нийгмийн хамгааллын үйл ажиллагаанд 2018 онд 2,556.2 тэрбум төгрөг төсөвлөсөн нь Монгол Улсын төсвийн зарлагын 26%-ийг эзэлж байна. Энэ нь өмнөх оноос 292.9 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

**2,556.2 тэрбум**

| | 2018 (тэрбум) | 2017 оноос |
|---|---|---|
| Нийгмийн даатгал | 1,808.3 | ▲13.4% |
| Нийгмийн халамж | 675.4 | ▲10.8% |
| Бодлого, удирдлага | 6.3 | ▲112.1% |
| Хөрөнгө оруулалт | 17.3 | ▲122.0% |
| Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөр | 48.8 | ▲2.0% |




| Урсгал зардал | 2,538.9 |
|---|---|
| - Цалин, НДШ | 42.4 |
| - Бараа үйлчилгээ | 31.4 |
| - Татаас | 27.4 |
| - Урсгал шилжүүлэг | 2,437.7 |

### ЗАРДЛЫН ӨӨРЧЛӨЛТ

**Цалинтай ээж**

**81.0** тэрбум — 0-3 насны хүүхдээ асарч байгаа эхэд сар бүр 50,000 төгрөг

**15.8** тэрбум — 0-18 насны 3 ба түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт улирал бүр 240,000 төгрөг

**Нийгмийн халамж**

**16.2** тэрбум — Хүнсний талон хөтөлбөрийн хамралт 2 дахин, мөнгөн дүн 20% хүртэл нэмэв

**Малчны тэтгэвэр**

**44.5** тэрбум — Тэтгэвэрт гарах насыг 5 жилээр урагшлуулснаас нэмэгдэх зардал

**Тэтгэвэр, тэтгэмж нэмэгдсэн**

**137.3** тэрбум — Тэтгэвэр, тэтгэмжийг инфляцийн түвшинтэй уялдуулан нэмэгдүүлэх

**53.6** тэрбум — Тэтгэвэр авагчид 9,800-аар нэмэгдэж тэтгэвэр, тэтгэмж бодох цалингийн өсөлттэй холбоотойгоор нэмэгдэх

**Эрүүл мэндийн даатгалын шимтгэл**

**9.2** тэрбум — Нийгмийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн хөдөлмөрийн насны 160,000 иргэний ЭМД шимтгэлийг төр хариуцах

## НИЙГМИЙН ДААТГАЛ

Иргэд шимтгэл төлж нийгмийн даатгалд хамрагдсанаар өндөр наслах, хөдөлмөрийн чадвараа алдах, ажилгүй болоход өөрт нь эсвэл даатгуулагч нас барахад түүний асрамжинд байсан хөдөлмөрийн чадваргүй гишүүдэд нь нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх үүсдэг.

Нийгмийн даатгалын сан нь бие даасан үндсэн дөрвөн сантай бөгөөд тус бүрдээ өөр, өөрийн онцлог зориулалт бүхий тэтгэвэр тэтгэмжийг олгодог.

Нийгмийн даатгалын сангийн 2018 оны төсвийн нийт орлого нь 1,911.2 тэрбум төгрөг, нийт зарлага нь 1,808.3 тэрбум төгрөг байна.

| Нийгмийн даатгалын сан | Мөнгөн дүн (тэрбум төгрөг) |
|---|---|
| **Орлого** | **1,911.2** |
| Шимтгэлийн орлого | 1,240.9 |
| Бусад орлого | 60.5 |
| Улсын төсвөөс олгох татаас | 609.8 |
| **Зарлага** | **1,808.3** |
| Тэтгэврийн даатгалын сан | 1,619.6 |
| Тэтгэмжийн даатгалын сан | 102.4 |
| ҮОМШӨ-ний даатгалын сан | 31.7 |
| Ажилгүйдлийн даатгалын сан | 35.4 |
| Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны төлбөр | 0.1 |
| Үйл ажиллагааны зардал | 19.0 |

**2018 оны 2 сарын 1-ээс эхлэн**

- Тэтгэврийг **27,000** төгрөгөөр нэмсэн.
- Бүрэн тэтгэврийн доод хэмжээ **280,000** төгрөг
- Хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээ **243,000** төгрөг болов.

**ҮОМШӨ-ний тэтгэвэр, тэтгэмж**
**28.5** тэрбум
**6.1** мянган хүн

**Тахир дутуу даатгуулагчийн сувиллын газрын хувьсах зардал**
**2.0** тэрбум

**Урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал**
**1.1** тэрбум

**Өндөр насны тэтгэвэр**
**1,227.0** тэрбум
**290.7** мянган хүн

**Тэтгэврийн Даатгал**
Орлого: **1,009.8**
Зарлага: **1,619.6**
Өндөр наслах, тахир дутуу болоход хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл, нас барахад хөдөлмөрийн чадваргүй гэр бүлийн гишүүнд.

**Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгал**
Орлого: **140.3** Зарлага: **31.7**
Ажлаа хийж байхдаа үйлдвэрлэлийн болон түүнтэй адилтгах хүчин зүйлийн үйлчлэлд өртсөн тохиолдолд олгоно.

**Хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж**
**17.2** тэрбум
**117.2** мянган хүн

**Тахир дутуугийн тэтгэвэр**
**211.8** тэрбум
**70.2** мянган хүн

**НИЙГМИЙН ДААТГАЛ**

**Тэтгэмжийн даатгал**
Орлого: **113.9**
Зарлага: **102.4**
Даатгуулагчийг хөдөлмөрийн чадвараа түр алдах, жирэмсэн болох, амаржих, нас барахад олгоно.

**Оршуулгын тэтгэмж**
**13.4** тэрбум
**13.4** мянган хүн

**Тэжээгчээ алдсаны тэтгэвэр**
**63.3** тэрбум
**20.1** мянган хүн

**Ажилгүйдлийн даатгал**
Орлого: **37.4** Зарлага: **35.4**
Даатгуулагчийг ажилгүй болох хугацаанд цалингийн 45-70%-аар ажлын 76 өдрийн хугацаанд олгоно.

**Жирэмсэн болон амаржсан эхийн тэтгэмж**
**71.7** тэрбум
**61.0** мянган хүн

**Цэргийн тэтгэвэр**
**116.5** тэрбум
**17.2** мянган хүн

**Ажилгүйдлийн тэтгэмж**
**35.3** тэрбум
**25.1** мянган хүн

211238 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4-р хороо Бага тойруу 13/1
**www.ndaatgal.mn** Нийгмийн даатгалын ерөнхий газрын цахим хуудас
**undeg@ndaatgal.mn** Цахим шуудан илгээх
**7777-1289**
**328030 / 321162** Мэргэжлийн зөвлөгөө авах

## НИЙГМИЙН ХАЛАМЖ

Эрүүл мэнд, гэр бүлийн халамж, асрамж дутагдалтай, бусдын тусламжгүйгээр хэвийн амьдрах боломжгүй дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай иргэний наад захын хэрэгцээг нь хангах зорилгоор улсаас олгож буй мөнгөн тэтгэвэр, тэтгэмж болон тусгайлсан үйлчилгээг “нийгмийн халамж” гэнэ.

2018 онд нийгмийн халамжийн хөтөлбөрт 675.4 тэрбум төгрөг батлагдсанаас 647.9 тэрбум нь нийгмийн халамжийн сангийн зардал, үлдсэн 27.5 тэрбум нь улс болон орон нутгийн асрамжийн газар болон хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын үйл ажиллагааны зардал юм.

### Ахмад настны нийгмийн халамж, үйлчилгээ

**28.7** ▲ 16.5% 2017 оноос

Ахмад настны тухай хуулинд заасан хувь хэмжээгээр **211,700** гаруй иргэнд

### Хөгжлийн бэрхшээлтэй иргэний халамж, үйлчилгээ

**12.3** ▲ 5.2% 2017 оноос

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулинд заасанаар **51,700** гаруй иргэнд

### Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамж, үйлчилгээ

**3.3** ▲ 74.6% 2017 оноос

Нийгмийн халамжийн тухай хуулийн 18-р зүйлд заасан хэмжээгээр **36,400** гаруй иргэнд

### Жирэмсэн, хөхүүл эхийн тэтгэмж

**19.8** ▼ 54.8% 2017 оноос

Сар бүр **40,000** төгрөгийг **98,900** гаруй иргэнд

### Халамжийн тэтгэвэр

**110.7** ▲ 13.3% 2017 оноос

Сар бүр **155,000** төгрөгийг **62,700** гаруй иргэнд

### Онцгой мөнгөн тэтгэмж

**23.1** ▲ 5.6% 2017 оноос

Нийгмийн халамжийн тухай хуулийн 13.1.3-д заасан хувь хэмжээгээр **76,400** гаруй иргэнд

### Бусад тэтгэмж

**58.1** ▲ 2017 оноос

### Халамжийн тэтгэмж

**38.8** ▲ 8.1% 2017 оноос

Сар бүр **70,000** төгрөгийг **50,300** гаруй иргэнд

*<<2018 оны 2 сарын 1-ээс нийгмийн халамжийн тэтгэврийг 140,000-аас 155,000 төгрөг, тэтгэмжийг 64,000-аас 70,000 төгрөг болгож нэмэгдүүлсэн.>>*

### Цалинтай ээж

**96.8** ▲ ШИНЭ 2017 оноос

**151,500** гаруй иргэнд

| | |
|---|---|
| 0-3 насны хүүхэд асрахад сар бүр | 50,000 ₮ |
| 0-18 насны 3, түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эцэг, эхэд улирал бүр | 240,000 ₮ |

### Алдарт эхийн тэтгэмж

**29.4** ▲ 0% 2017 оноос

**209,100** гаруй эхэд

| | |
|---|---|
| I одонтой ээжид жилд 1 удаа | 200,000 ₮ |
| II одонтой ээжид жилд 1 удаа | 100,000 ₮ |

*Өрхийн амьжиргааны түвшинг 0-1000 хүртэл оноогоор эрэмбэлсэн судалгаанд үндэслэн хүнсний талон, хүүхдийн мөнгийг олгодог.*

*Хүнсний талоныг Улаанбаатар хотод 0-292.5, орон нутагт 0-310.0 оноотой өрхөд олгож байна.*

### Хүнсний талон

**42.2** ▲ 92.3% 2017 оноос

**288,700** гаруй иргэнд

| | |
|---|---|
| Том хүнд сар бүр | 16,000 ₮ |
| Хүүхдэд сар бүр | 8,000 ₮ |

### Хүүхдийн мөнгө

**164.2** ▼ 38.3% 2017 оноос

0-554.0 оноо

Сар бүр **20,000** төгрөгийг **684,000** гаруй хүүхдэд

### Насны хишиг

**20.5** ▲ 0% 2017 оноос

Жилд 2 удаа наснаас хамаарч **128,600** гаруй иргэнд

| 65-69 нас | 70-79 нас | 80-89 нас | 90-с дээш |
|---|---|---|---|
| 50,000 ₮ | 80,000 ₮ | 150,000 ₮ | 250,000 ₮ |

### НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТАЛААР ЗӨВЛӨГӨӨ МЭДЭЭЛЭЛ АВАХ ЭХ ҮҮСВЭР

Харьяа дүүрэг, аймгийн Нийгмийн халамж, үйлчилгээний газар

**www.hudulmur-halamj.gov.mn**

**1800 – 1220**

## БОЛОВСРОЛ

Ирээдүйн эзэд болсон хүүхэд залуучуудын боловсролын чанар хүртээмж, сурч боловсрох тав тухтай орчныг бүрдүүлэхэд дэлхийн улс орнууд ихээхэн анхаардаг бөгөөд энэ нь хөгжлийн гол тулгуур гэж үздэг. Монгол Улсын хувьд төрийн өмчийн цэцэрлэг, сургууль, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвд суралцагсдыг үнэ төлбөргүй сургадаг бол хувийн хэвшлийн боловсролын байгууллагуудад төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлдэг. Харин дотоодын их, дээд сургуульд суралцаж байгаа залуust сургалтын төлбөрийн зээлийг хүүгүй олгож байна. Түүнчлэн гадаадад сурах сонгон шалгаруулалтад тэнцсэн оюутнуудад сургалтын төлбөрийн зээллэг олгодог.

**ТӨСВИЙН 2018 ОНД ОНЦЛОГ**

- ЕБС-ийн хичээлийн 3 ээлжийг 2 ээлжид шилжүүлэх “3 ээлжгүй сургууль” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- “Хүүхэд бүр цэцэрлэгт” хөтөлбөрийн хүрээнд хот суурин газарт цэцэрлэгийн насны хүүхдийг бүрэн хамрагдах нөхцлийг бүрдүүлнэ.
- “Төлбөрийн дарамтгүй оюутан” зорилтыг хэрэгжүүлж оюутны хөгжлийн зээлийг саадгүй олгох нөхцөл, журмыг бүрдүүлнэ.
- Зорилтот бүлгийн оюутан, сурагчдад олгох сургалтын төлбөрийн буцалтгүй тусламжийн хэмжээг нэмэгдүүлнэ.

**1,428.1 тэрбум**

| | 2018 (тэрбум) | 2017 оноос |
|---|---|---|
| Сургуулийн өмнөх боловсрол | 322.1 | ▲ 12.0% |
| Ерөнхий боловсрол | 651.0 | ▲ 3.4% |
| Дээд боловсрол | 135.3 | ▲ 28.6% |
| Мэргэжлийн боловсрол | 56.0 | ▼ 3.6% |
| Боловсрол, ШУ-ны бодлого удирдлага | 263.7 | ▲ 94.3% |

Хөрөнгийн зардал 211.6

Эргэж төлөгдөх цэвэр зээл 96.8

тэрбум төгрөг

| Урсгал зардал | 1,119.7 |
|---|---|
| - Цалин, НДШ | 666.2 |
| - Бараа үйлчилгээ | 279.1 |
| - Татаас | 64.8 |
| - Урсгал шилжүүлэг | 109.6 |

## ЗАРДЛЫН ӨӨРЧЛӨЛТ

**Цэцэрлэгийн хүүхэд 26,479 Сурагчид 40,159 нэмэгдэх тул**

**23.4 тэрбум** Төрийн өмчийн цэцэрлэг, сургуулийн хувьсах зардлын өсөлт

**18.9 тэрбум** Хувийн өмчийн сургууль, цэцэрлэгийн хувьсах зардлын өсөлт

**Салбарын шинэчлэл, инноваци**

**2.0 тэрбум** Шинжлэх ухааны эрдэм шинжилгээний зардлын өсөлт

**3.1 тэрбум** Сумын 800 орчим сургууль, 1200 цэцэрлэгийг шилэн кабелиар УБ-тай холбож өргөжүүлэх

**Шинээр ашиглалтанд орж буй барилга байгууламж**

**3.9 тэрбум** 30 хүүхдийн цэцэрлэгийн өргөтгөлтэй холбоотойгоор

**15.3 тэрбум** Шинээр 49 ЕБС-ийн хичээлийн байр, дотуур байр, спорт заалны өргөтгөл ашиглалтанд ороход

**“Хүүхэд бүр цэцэрлэг” “3 ээлжгүй сургууль” хөтөлбөр**

**201.8 тэрбум** Шинээр 111 цэцэрлэг, 79 сургууль барих

**9.8 тэрбум** Боловсролын салбарын их засвар, тоног төхөөрөмж

## СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛ

**322.1**

**Төсвөөс олгох санхүүжилт** (тэрбум.төг)

| | | |
|---|---|---|
| Улсын цэцэрлэг | 87.2% | 281.0 |
| Хувийн цэцэрлэг | 10.8% | 34.6 |
| Хүүхэд харах үйлчилгээнд | 2.0% | 6.5 |

| | Нийт | Төрийн | Хувийн |
|---|---|---|---|
| Цэцэрлэгийн тоо | 1,477 | 878 | 559 |
| Хүүхдийн тоо | 257,543 | 217,052 | 40,491 |
| Багшийн тоо | 16,559 | 11,701 | 4,858 |
| Хамран сургалтын хувь | 84.6% | | |
| Тусгай хэрэгцээт цэцэрлэгт хамрагдах хүүхдийн тоо | 488 | | |
| Хүүхэд харах үйлчилгээнд хамрагдах хүүхдийн тоо | 5,275 | | |

Хувийн цэцэрлэгт дараах нормативийн дагуу нэг хүүхдэд ногдох хувьсах зардлаар тооцож санхүүжилт олгодог бол хүүхэд харах үйлчилгээнд хувьсах зардал болон хоолны зардлыг олгодог.

**Хувьсах зардал** (1 хүүхдэд 1 жилд)

- Сумын цэцэрлэгт **998,200** төгрөг
- Аймгийн төвд **812,300** төгрөг
- Нийслэлийн цэцэрлэгт **807,800** төгрөг

**Хоолны зардал** (1 хүүхдэд 1 өдөрт)

- Энгийн (8-10 цаг) цэцэрлэгт **1,650** төгрөг
- Сувиллын болон тусгай (24 цаг) цэцэрлэгт **2,400** төгрөг

Төрөөс хүүхдийн сурч хөгжих боломжийг хангахад анхаарч төрийн болон хувийн боловсролын байгууллагыг улсын төсвөөс санхүүжүүлдэг. Улсын цэцэрлэг, сургуульд хувьсах, тогтмол болон хоолны зардлыг олгодог тул 100% үнэ төлбөргүй хамрагдана.

## ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛ

**651.0**

**Төсвөөс олгох санхүүжилт** (тэрбум.төг)

| | | |
|---|---|---|
| Улсын сургууль | 84.7% | 551.4 |
| Хувийн сургууль | 2.5% | 16.3 |
| Үдийн цай хөтөлбөр | 5.0% | 32.5 |
| Сурах бичиг | 0.6% | 4.2 |
| Дотуур байрны үйлчилгээ | 7.2% | 46.6 |

| | Нийт | Төрийн | Хувийн |
|---|---|---|---|
| Сургуулийн тоо | 844 | 686 | 158 |
| Хүүхдийн тоо | 599,414 | 564,920 | 34,494 |
| Багшийн тоо | 29,490 | 26,990 | 2,500 |
| Хамран сургалтын хувь | 95.8% | | |
| Дотуур байрны тоо | 517 | | |
| Дотуур байранд амьдарч буй хүүхдийн тоо | 39,264 | | |
| Үдийн цай хөтөлбөрт хамрагдах хүүхдийн тоо | 321,762 | | |
| Тусгай хэрэгцээт сургуульд хамрагдах хүүхдийн тоо | 2,209 | | |

Нэг сурагчийн нэг өдрийн хоолны зардлыг тооцох норматив санхүүжилт

| | | |
|---|---|---|
| Үдийн цайны зардал | Бага | 600 төг |
| | Тусгай | 2,400 төг |
| Дотуур байрны хүүхдийн хоолны зардал | ЕБС МСҮТ | 2,315 төг |

### ЕБС-д НЭГ ХҮҮХДЭЭР ТООЦОЖ ОЛГОДОГ ХУВЬСАХ ЗАРДАЛ (мян.төг)




*Эх сурвалж: Засгийн газрын 2016 оны 242 дугаар тогтоол*

## МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ

**Төсвөөс олгох санхүүжилт** (тэрбум.төг)

**56.0**

| | | |
|---|---|---|
| Үйл ажиллагааны зардал | 92.1% | **51.6** |
| Дотуур байрны үйлчилгээ | 5.2% | **2.9** |
| Оюутны нийтийн тээврийн хөнгөлөлт | 2.7% | **1.5** |

| | Нийт | Төрийн | Хувийн |
|---|---|---|---|
| МСҮТ-ийн тоо | 83 | 50 | 33 |
| Суралцагчдын тоо | 35,831 | 25,707 | 10,124 |

Төрийн болон хувийн өмчийн МБС-ын байгууллагыг газарзүйн байршлаас хамааруулан хувьсах зардлаар улсын төсвөөс санхүүжүүлдэг. Техникийн болон мэргэжлийн боловсролыг төрийн өмчийн сургуульд үнэ төлбөргүй олгодог.

## БОЛОВСРОЛ, ШУ-НЫ БОДЛОГО, УДИРДЛАГА

**Төсвөөс олгох санхүүжилт** (тэрбум.төг)

**263.7**

| | | |
|---|---|---|
| Боловсролын удирдлага | 85.2% | **224.6** |
| Шинжлэх ухаан, технологи | 13.5% | **35.7** |
| Насан туршийн болон албан бус боловсрол | 1.3% | **3.4** |

| | |
|---|---|
| БСШУСЯ, харьяа байгууллагууд | 33 |
| Эрдэм шинжилгээний байгууллага | 11 |
| Албан бус боловсролд хамрагдах хүүхдийн тоо | 11,370 |

Багш нарт олгох улирлын урамшууллын хэмжээг 5% хүртэл нэмж, үндсэн цалингийн 20% хүртэл урамшууллыг сар бүр тооцож, улирлаар олгохоор болов.

## ДЭЭД БОЛОВСРОЛ

**Төсвөөс олгох санхүүжилт** (тэрбум.төг)

**135.3**

| | | |
|---|---|---|
| Дотоодод суралцаж буй оюутанд | 73.8% | **99.9** |
| Монголд суралцаж буй гадаад оюутны амжиргааны тэтгэлэг | 0.7% | **0.9** |
| Гадаадад суралцаж буй Монгол оюутанд | 19.0% | **25.7** |
| Байгууллагын үйл ажиллагааны зардал | 6.5% | **8.8** |

| | Нийт | Гадаад | Төрийн | Хувийн |
|---|---|---|---|---|
| Их, дээд сургуулийн тоо | 96 | 3 | 18 | 75 |
| Оюутны тоо | 155,248 | 147 | 89,473 | 65,628 |

| | |
|---|---|
| Дэлхийн шилдэг их, дээд сургуульд хамрагдагсдын тоо | 295 |
| Багш инженерээр суралцагчаас төлбөрийн хөнгөлөлт авах оюутан | 1,705 |
| Багшлах дадлагад хамрагдсан суралцагчийн тоо | 704 |

Өмнөх жилд дотоодод суралцаж буй 2,200 оюутан 5 тэрбум төгрөгний зээл авсан бол 2017-2018 оны хичээлийн жилд 35-37 мянган оюутанд 75 тэрбум төгрөгийн зээл олгохоор төлөвлөөд байна.

**Гадаадад суралцаж буй оюутанд (тэрбум төгрөг)**

| | | |
|---|---|---|
| **14.5** ▲0% 2017 он | **3.9** ▼3.9% 2017 он | **7.3** ▲0% 2017 он |
| Дэлхийн шилдэг 100 сургуульд суралцагчдын сургалтын төлбөрийн зээл | Засгийн газрын хоорондын гэрээгээр гадаадад суралцагсдын зардал | Засгийн газрын гэрээгээр гадаадын магистр, доктурт суралцагчдад олгох зээл |

**Дотоодод суралцаж буй оюутанд (тэрбум төгрөг)**

| | | |
|---|---|---|
| **75.0** ▲81.5% 2017 он | **12.5** ▼0.1% 2017 он | **2.8** ▼12.7% 2017 он |
| Оюутны хөгжил сургалтын төлбөрийн зээл | Зорилтот бүлэгт олгож буй сургалтын төлбөрийн буцалтгүй тэтгэлэг | Багш мэргэжлээр суралцаж буй оюутан, магистрантуудад олгох сургалтын төлбөр |
| **0.5** ▼55.6% 2017 он | **1.0** ▼0% 2017 он | **8.0** ▼16.3% 2017 он |
| Багш мэргэжлээр суралцаж буй оюутнуудад орон нутагт багшлах дадлага хийхэд олгодог тэтгэлэг | Хөдөө, орон нутгийн оюутнуудын замын зардлын хөнгөлөлт | Нийтийн тээврээр үнэ төлбөргүй зорчих |

### ОЮУТНЫ ХӨГЖЛИЙН ЗЭЭЛИЙГ ЧӨЛӨӨТЭЙ САADГҮЙ, ОЛГОНО

Сургалтын голч нь 2.8-с дээш буюу санхүүгийн бололцоогүй боловч амжилттай суралцаж буй залуус Боловсролын зээлийн сангаас зээл авч болно.

Багшийн хөгжлийн ордон 2-р давхар, Улаанбаатар хот

**www.elf.mn** Боловсролын зээлийн сан

**contact@elf.mn** Цахим шуудан илгээх

**70109399** Зээлийн алба /дотоод/

# БАТЛАН ХАМГААЛАХ, НИЙГМИЙН ХЭВ ЖУРАМ

Улс орныг батлан хамгаалах, хил хамгаалах, гамшгаас урьдчилан сэргийлэх, цагдаа, прокурор, шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагааг зохион байгуулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, эрх зүйн бодлого боловсруулах үйл ажиллагаа энэхүү хөтөлбөрт хамрагдаж байна.

**ТӨСВИЙН 2018 ОНД ОНЦЛОГ**

- Алслагдсан цэргийн ангийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангана.
- Эрүүгийн хууль, Зөрчлийн хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуулиудын хэрэгжилтийг хангана.
- Хар тамхи, мансууруулах бодис, хүн худалдаалахтай тэмцэнэ.
- Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлнэ.

**892.2 тэрбум**

| | 2018 (тэрбум) | 2017 оноос |
|---|---|---|
| Зэвсэгт хүчний үйл ажиллагаа | 236.8 | ▲ 3.4% |
| Хил хамгаалах | 124.3 | ▼ 2.9% |
| Шүүх байгууллага | 52.6 | ▲ 3.5% |
| Прокурорын хяналт | 28.9 | ▲ 8.3% |
| Цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэл, шүүхийн шинжилгээ | 251.8 | ▲ 0.6% |
| Үндэсний аюулгүй байдлыг хамгаалах | 81.2 | ▲ 3.2% |
| Гамшгаас урьдчилан сэргийлэх, тэмцэх | 86.2 | ▲ 9.3% |
| Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх | 7.2 | ▲ 116.0% |
| Эрх зүй, нийгмийн хэв журам, аюулгүй байдлын удирдлага, судалгаа шинжилгээ | 23.2 | ▲ 25.5% |




| Урсгал зардал | 859.5 |
|---|---|
| - Цалин, НДШ | 534.1 |
| - Бараа үйлчилгээ | 260.1 |
| - Татаас | 35.5 |
| - Урсгал шилжүүлэг | 29.8 |

## ЗАРДЛЫН ӨӨРЧЛӨЛТ

**Гамшгаас урьдчилан сэргийлэх, тэмцэх**

**4.3** тэрбум — Суманд гал унтраах 6 анги, эрэн хайх, аврах 3 бүлэг байгуулах

**2.0** тэрбум — Гамшгийн эрсдлийг бууруулах Азийн сайд нарын II дугаар бага хурлыг Монголд зохион байгуулах

**Үйл ажиллагаа өргөжсөнтэй холбоотой**

**7.1** тэрбум — Цэргийн төв эмнэлэг, Зэвсэгт хүчний жанжин штабын урсгал зардлын өсөлт

**1.9** тэрбум — Шинэ нисэх онгоцны буудал ашиглалтад оруулах, Гашуун сухайтын боомтыг өргөжүүлэх хилийн шалган нэвтрүүлэх зардал

**Алслагдсан цэргийн ангийн албан хаагчийн нийгмийн баталгаа**

**1.6** тэрбум — Алслагдсан цэргийн ангид алба хааж буй батлан, хил хамгаалахын офицер, ахлагч нарын сургуулийн хүүхдийн боловсролыг дэмжихэд 240,000 төгрөгийг улиралд нэг удаа олгох

**Эрх зүй, нийгмийн хэв журам, аюулгүй байдлын удирдлага**

**2.2** тэрбум — Эрүүгийн хууль, Зөрчлийн хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуулиудын хэрэгжилтийг хангах

**3.9** тэрбум — Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлын өсөлт

**2.5** тэрбум — Бүх нийтийн эрх зүйн боловсрол, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх, Хүн худалдаалахтай тэмцэх хөтөлбөрүүдийн зардлын өсөлт

# ЭРҮҮЛ МЭНД

Иргэн бүрт аюулгүй чанар хүртээмжтэй эмнэлгийн тусламж үйлчилгээг шуурхай хүргэх замаар амьдралын чанарыг сайжруулж, хүн амын дундаж наслалтыг уртасгах зорилт тавин ажиллаж байна.
Энэ зорилтын хүрээнд иргэдийн урьдчилан сэргийлэх мэдлэг дадал, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх, анхан шатны тусламж үйлчилгээг өрх, сумын эрүүл мэндийн төвөөр дамжуулан шуурхай үзүүлэх, эрүүл мэндийн даатгалын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх бодлого хэрэгжүүлж байна.

**ТӨСВИЙН 2018 ОНД ОНЦЛОГ**

- Эрүүл мэндийн даатгалын санг нийгмийн даатгалын сангаас бие даалгав.
- "Элэг бүтэн Монгол" хөтөлбөрийг үргэлжлүүлнэ.
- Эрүүл мэндийн даатгалаар санхүүжих тусламж, үйлчилгээний нэр, төрөл, хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- Анхан шатны эмнэлгийн тусламж үйлчилгээг сайжруулна.

**825.7 тэрбум**

| | 2018 (тэрбум) | 2017 оноос |
|---|---|---|
| Эрүүл мэндийн даатгал | 126.8* | ▲10.4% |
| Эрүүл мэндийн бодлого, удирдлага | 109.4 | ▼4.9% |
| Эмнэлгийн тусламж үйлчилгээ болон нийгмийн эрүүл мэнд | 589.4 | ▲6.8% |

*126.8* - ЭМД-ын сангаас улсын эмнэлэгт өгч буй санхүүжилтийг оруулаагүй дүн*




| | | |
|---|---|---|
| Хөрөнгийн зардал | | 63.5 |
| Урсгал зардал | | 762.2 |
| - Цалин, НДШ | | 307.6 |
| - Бараа үйлчилгээ | | 293.3 |
| - Татаас | | 47.5 |
| - Урсгал шилжүүлэг | | 113.9 |

## ЗАРДЛЫН ӨӨРЧЛӨЛТ

**Нэн шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, нийгмийн эрүүл мэнд**

**9.3 тэрбум** Цусны хавдар, сүрьеэ, эрхтэн шилжүүлэх, дархлаа дарангуйлах, гемодиалез, уушгины хатгалгааны вакцин г.м зардлын өсөлт

**2.0 тэрбум** Эрүүл мэндийг дэмжих сан болон бусад үйл ажиллагааны зардлын өсөлт

**Эрүүл мэндийн байгууллагын орчин**

**6.4 тэрбум** Шинэ эмнэлэг болон эмнэлгийн өргөтгөл ашиглалтад орсноос нэмэгдэх зардал

**2.3 тэрбум** Эмнэлгийн тоног төхөөрөмжийн найдвартай, хэвийн үйл ажиллагааг хангах зардлын өсөлт

**Анхан шатны эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ**

**4.4 тэрбум** Өрх, сумын эрүүл мэндийн төвийн тарифын өөрчлөлт, тогтмол зардлын өсөлт

**Эмнэлгийн тусламж үйлчилгээний цар хүрээ**

**6.4 тэрбум** Өндөр өртөгтэй мэс заслын хүртээмжийг нэмэгдүүлэх

**3.3 тэрбум** Эмнэлгийн тусламж үйлчилгээний цар хүрээг нэмэгдүүлэх

**Эрүүл мэндийн яамны төсөвлөсөн хөрөнгө оруулалтын зардал**

**21.7 тэрбум** Барилга, байгууламж барихад 45.8 тэрбум төсөвлөсөн нь өмнөх жилээс өссөн дүн

**-5.6 тэрбум** Их засварт 4.9 тэрбум төсөвлөсөн нь өмнөх жилээс буурсан дүн

**-17.1 тэрбум** Тоног төхөөрөмж худалдан авахад 10.1 тэрбум, өмнөх жилээс буурсан дүн

**Төрийн тусгай алба хаагчдын нэгдсэн эмнэлгийн хөрөнгө оруулалт**

**1.1 тэрбум** Тоног төхөөрөмж худалдан авахад 2.7 тэрбум, өмнөх жилээс өссөн

## ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ БОЛОН НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНД

Монгол хүний эрүүл мэнд, түүнд нөлөөлж буй нийгэм, эдийн засгийн орчин болон удамшлын хүчин зүйлсийг судлах, нийт хүн амд эрүүл зан үйлийг төлөвшүүлэх, эрсдэлт зан үйлийг өөрчлөх, эрүүл амьдралын ээлтэй орчинг бий болгох, өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх, хүн амд эрүүл мэндийн боловсрол, нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ олгодог.

### Анхан шатлалын эрүүл мэндийн байгууллага

**Өрхийн эрүүл мэндийн төв**

Нийт 218 — 29.3 тэрбум ▲ 6.9% 2017 оноос

Жилд дунджаар 6 сая орчим иргэнд үйлчилдэг.

**Сумын эрүүл мэндийн төв**

Нийт 331 — 101.2 тэрбум ▲ 2.4% 2017 оноос

Жилд дунджаар:
- Амбулатори: **8 сая**
- Хэвтэн эмчлүүлэх: **120 мянга**

### Хоёрдогч шатлалын эрүүл мэндийн байгууллага

**Дүүргийн нэгдсэн эмнэлэг**

Нийт 12 — 55.3 тэрбум ▲ 7.6% 2017 оноос

**Хөдөөгийн нэгдсэн эмнэлэг**

Нийт 6 — 11.0 тэрбум ▲ 3.8% 2017 оноос

**Аймгийн нэгдсэн эмнэлэг**

Нийт 16 — 91.5 тэрбум ▲ 3.2% 2017 оноос

Жилд дунджаар:
- Амбулатори: **4 сая**
- Хэвтэн эмчлүүлэх: **250 мянга**

### Гуравдагч шатлалын эрүүл мэндийн байгууллага

**Бүсийн оношлогоо, эмчилгээний төв**

Нийт 5 — 36.3 тэрбум ▲ 5.6% 2017 оноос

**Төрөлжсөн мэргэжлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төв**

Нийт 13 — 199.3 тэрбум ▲ 8.6% 2017 оноос

Жилд дунджаар:
- Амбулатори: **2 сая**
- Хэвтэн эмчлүүлэх: **200 мянга**

### Эрүүл мэндийн байгууллага

**Нийслэлийн амаржих газар**

Нийт 3 — 17.2 тэрбум ▲ 10.1% 2017 оноос

**Бусад байгууллага**

Нийт 28 — 28.4 тэрбум ▲ 7.6% 2017 оноос

- Уламжлалт анагаах ухааны төв
- Рашаан сувиллын төв
- Түргэн тусламжийн төв
- Зоонозын өвчин судлалын төв
- Цус сэлбэлт судлалын үндэсний төв
- Эмгэг судлалын үндэсний төв
- Наркологийн эмнэлэг
- Шүд, эрүү, нүүрний төв
- Энэрэл эмнэлэг

### Эрүүл мэндийн арга хэмжээ, үйлчилгээ

**Гемодиализийн төлбөр**

3.1 тэрбум ▲ 17.1% 2017 оноос

Хувийн эмнэлгүүдэд нэг удаад 125,000 төгрөгөөр тооцож олгодог

**Товлолт вакцинжуулалт**

8.0 тэрбум ▲ 10.9% 2017 оноос

6 төрлийн 10 гаруй өвчнөөс сэргийлэх вакцин үнэ төлбөргүй

**Хатгааны эсрэг вакцин-ШИНЭ**

1.0 тэрбум ▲ 16.5% 2017 оноос

0-1 насны хүүхэд үнэ төлбөргүй.

### Эрүүл мэндийн бодлого удирдлага

**Удирдах байгууллагуудын үйл ажиллагааны зардал**

18.9 тэрбум

- Эрүүл мэндийн яам
- Эрүүл мэндийн хөгжлийн төв
- Нийслэл, 21 аймгийн эрүүл мэндийн газар

12.5 тэрбум ▼ 9.8% 2017 оноос

Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмж **924 хүн**

14.5 тэрбум ▼ 2.8% 2017 оноос

Орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан төрийн албан хаагчид олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж **4,165 хүн**

## ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛ

Эрүүл мэндийн даатгал нь даатгуулагчид эрүүл мэндийн улмаас учирч болзошгүй санхүүгийн эрсдэлийг хуваалцах зорилготой. Шимтгэлээ төлснөөр иргэн эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах тусламж, үйлчилгээг гэрээ бүхий эрүүл мэндийн байгууллагаас авах эрхтэй болдог. Дараах тусламж, үйлчилгээг эрүүл мэндийн даатгалаас санхүүжүүлж байна.

**180.2 тэрбум**

**Улсын эмнэлгийн тусламж үйлчилгээ**

- Хэвтэн эмчлүүлэхэд оношоос хамаарч 145,500 - 804,090 төгрөг
- Амбулаторийн үзлэгт 15,000 - 16,200 төгрөг
- Оношлогоо шинжилгээнд улирлад 165,000 төгрөг

**34.3 тэрбум**

**Өндөр өртөгтэй мэс заслын зарим тусламж, үйлчилгээ**

Өндөр өртөг бүхий 18 төрлийн тусламж, үйлчилгээ, 484 гаруй нэр төрлийн эмнэлгийн хэрэгсэл, протезийн үнийн 75% хүртэл буюу 28.7 сая төгрөг хүртэл

**42.0 тэрбум**

**Хувийн эмнэлгийн тусламж үйлчилгээ**

Сонгон шалгаруулалтад тэнцсэн хувийн хэвшлийн эмнэлэгт хэвтэн эмчлүүлэх, уламжлалт эмчилгээ, сэргээн засах, хөнгөвчлөх тусламж үйлчилгээ

**5.2 тэрбум**

**Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв**

2018 оноос эхлэн төвүүдээр үзүүлэх сэргээн засах үйлчилгээ, гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээ, өдрийн эмчилгээ, оношлогоо, шинжилгээ

**12.7 тэрбум**

**Рашаан сувилал**

- Рашаан сувилалд 110,000 төгрөг
- Клиник сувилалд 116,281 төгрөг
- Удаан хугацааны нөхөн сэргээх эмчилгээнд 132,473 төгрөг

**10.2 тэрбум**

**Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношлогоо шинжилгээ**

Давхардсан тоогоор 893.844 гаруй даатгуулагчийг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношлогоо шинжилгээнд хамруулах зардал

**23.4 тэрбум**

**"Элэг бүтэн Монгол" хөтөлбөр**

- Элэгний B, C вирусын идэвхжил тодорхойлох шинжилгээ
- Элэгний C вирусын эсрэг 5 төрлийн эмийн хөнгөлөлт хайрцаг тутамд 210,000 төгрөг.

**29.0 тэрбум**

**Эмийн үнийн хөнгөлөлт**

Жороор эрүүл мэндийн даатгалын сангаас 817 нэрийн эмийг 40-80% буюу 500 - 65,000 төгрөгийн хөнгөлөлттэй үнээр авна.

**4.3 тэрбум**

**Үйл ажиллагааны зардал болон бусад**

- Эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагааны зардалд 4.0 тэрбум
- Шүүхийн шийдвэр болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн илүү төлөлтийн буцаан олголт 0.3 тэрбум

### ГЭР БҮЛИЙН ГИШҮҮН ДААТГУУЛАГЧИЙН ЗАРДЛЫГ ШИЛЖҮҮЛЭН ЗАРЦУУЛАХ ЭРХ

Даатгуулагч таны эрүүл мэндийн даатгалын сангаас хариуцах тухайн жилийн зардлын дээд хязгаар хоёр сая төгрөгөөс хэтэрсэн тохиолдолд гэр бүлийн өөр нэг даатгуулагчийн зөвшөөрснөөр түүний даатгалаас нэг удаа шилжүүлэх боломжтой. Гэхдээ өндөр өртөгтэй мэс засал, хорт хавдрын химийн болон туяа эмчилгээнд дээд хязгаар хамаардаггүй.

## ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын хөгжлийг хангах, дэд бүтцийг сайжруулах, жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлж хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх нь эдийн засагт эерэг нөлөөтэй.

**ТӨСВИЙН 2018 ОНД ОНЦЛОГ**

- Малын эрүүл мэнд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- Буудай, жимс, жимсгэний тариаланг дэмжинэ.
- Дулааны шугам сүлжээний 6,2 км өргөтгөл хийнэ.
- Улаанбаатар хотын 20,000 өрхийг цахилгаантай болгоно.
- Шинээр 10 сумыг цахилгаан эрчим хүчинд холбоно.
- 661.2 км автозам, 58.4 м гүүрийг байнгын ашиглалтанд оруулна.
- Цэвэр усны 100 км, бохир усны 80 км шугам сүлжээг шинээр барих буюу шинэчилнэ.
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажилгүйдлийг бууруулна.
- Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.

* Зарим хөрөнгө оруулалт гадаад зээл, тусламж болон концессоор хийгдэнэ.

**641.9 тэрбум**

| | 2018 (тэрбум) | 2017 оноос |
|---|---|---|
| Хөдөө аж ахуй, газар тариалан, аж үйлдвэр | 100.3 | ▼ 54.3% |
| Эрчим хүч, уул уурхай | 83.6 | ▼ 46.6% |
| Зам тээвэр | 140.7 | ▼ 31.5% |
| Хот байгуулалт, нийтийн аж ахуй | 185.3 | ▲ 34.2% |
| Худалдаа | 1.4 | ▲ 3.0% |
| Харилцаа холбоо | 14.8 | ▲ 16.9% |
| Хөдөлмөр эрхлэлт | 116.1 | ▲ 83.4% |




| Урсгал зардал | 333.1 |
|---|---|
| - Цалин, НДШ | 46.8 |
| - Бараа үйлчилгээ | 156.4 |
| - Татаас | 80.9 |
| - Урсгал шилжүүлэг | 49.0 |

## ЗАРДЛЫН ӨӨРЧЛӨЛТ

### Хөдөө аж ахуй

- **4.7 тэрбум** Мал амьтны халдварт, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, оношлогоо шинжилгээний зардал
- **-3.4 тэрбум** Мах боловсруулах үйлдвэрт улсын төсвөөс олгох зээлийн хүүний хөнгөлөлтийн бууралт
- **2.0 тэрбум** Жимс, жимсгэний тариалан эрхлэлтийг дэмжихэд олгох татаас
- **2.8 тэрбум** Тариаланг дэмжих сангийн үйл ажиллагааны орлого өсч байгаатай холбоотой зардлын өсөлт
- **23.4 тэрбум** Улаанбуудайн үр худалдан авахад олгосон зээлийн эргэн төлөлт
- **40.0 тэрбум** Малын тэжээлийн нөөц бэлтгэхэд олгосон зээлийн эргэн төлөлт

### Бусад эдийн засгийн үйл ажиллагаа

- **1.5 тэрбум** Сүлжээний найдвартай ажиллагааг хангахын тулд "Радио телевизийн сүлжээ" ТӨҮГ-т олгодог татаас
- **37.1 тэрбум** Орон нутгийн төсвөөр хэрэгжих хот байгуулалт, тохижилтын зардлын өсөлт
- **3.4 тэрбум** Газрын зураглал, кадастерийн зардлын өсөлт

### Хөрөнгө оруулалт

- **-125.5 тэрбум** Нийт хөрөнгийн зардлын бууралт

## ТӨРӨӨС ЭРЧИМ ХҮЧ, ХӨДӨӨ АЖ АХУЙД ОЛГОХ ТАТААС

### ЭРЧИМ ХҮЧНИЙ АЛДАГДАЛД ОЛГОХ ТАТААС

*Эрчим хүчний үнийг нэмэгдүүлэхгүйн тулд төрөөс алдагдлыг нөхөхөд олгодог татаас бөгөөд 2018 онд нийт 17.1 тэрбум төгрөг төсөвлөв.*

**9.6** тэрбум
Цахилгаан дамжуулах системийн алдагдалд олгох татаас

**5.4** тэрбум
Дулааны станцын алдагдалд олгох татаас

**2.1** тэрбум
Дизелийн станцын алдагдалд олгох татаас

### ХӨДӨӨ АЖ АХУЙН ТАТААС, УРАМШУУЛАЛ



**15.0** тэрбум ▲ 0% 2017 оноос

**Улаанбуудайн урамшуулал**
Гурилын үйлдвэр, Тариалан эрхлэлтийг дэмжих сан, улсын нөөцөд нийлүүлсэн хүнсний улаанбудайнд
- I-III ангилалд 1 тоннд 60,000 төгрөг
- IV ангилалд 1 тоннд 50,000 төгрөг

**2.0** тэрбум ▲ ШИНЭ 2017 оноос

**Жимс, жимсгэний тариалан**
Жимсний аж ахуй эрхлэгч 5 жил хүртэлх хугацаанд хүүгүй зээл авна.

**22.6** тэрбум ▲ 0% 2017 оноос

**Ноосны урамшуулал**
Боловсруулах үндэсний үйлдвэрт тушаасан ноосонд
- Нарийн, нарийвтар ноос 1 кг 2,000 төгрөг
- Бүдүүн, бүдүүвтэр ноос 1 кг 1,000 төгрөг

**4.7** тэрбум ▼ 42.1% 2017 оноос

**Мах бэлтгэхэд олгох зээлийн хөнгөлөлт**
Мах боловсруулах үйлдвэрийн мах бэлтгэхэд олгосон арилжааны банкны зээлийн 8-10%-иар улсаас хөнгөлөлт үзүүлдэг

**11.8** тэрбум ▲ 0% 2017 оноос

**Арьс, ширний урамшуулал**
Боловсруулах үндэсний үйлдвэрт тушаасан стандартад нийцсэн арьс ширэнд
- Бод малын 1 ширхэг арьс 15,000 төгрөг
- Бог малын 1 ширхэг арьс 3,000 төгрөг

### ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРИЙГ ХӨГЖҮҮЛЭХ САН

**30 сая 2 тэрбум** зээлийн хэмжээ

**жилийн 3%-7%** зээлийн хүү

**5 жил хүртэл** зээлийн хугацаа

**326 - 489** хамрагдах төслийн тоо

**4,638** Бий болох ажлын байр

**97.8** тэрбум ▲ 93.3% 2017 оноос

**Төсөвлөсөн хөнгөлөлттэй зээл**

*Хөнгөлөлттэй зээлийн үр дүнд 4,638 ажлын байр шинээр бий болж өмнөх жилийн хүрсэн үр дүнгээс 65% нэмэгдэнэ гэж тооцсон.*

# СПОРТ, СОЁЛ УРЛАГ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ

Төрөөс спортыг хөгжүүлж, иргэдийнхээ бие бялдрыг сайжруулах, театр чуулгаар дамжуулан урлагийн боловсролыг дээшлүүлэх, орчин үеийн шаардлага хангасан үндэсний номын сан, музейтэй болохоор зорин ажиллаж байна. Түүнчлэн аялал жуулчлалын өрсөлдөх чадварыг бүс нутгийн хэмжээнд дээшлүүлж, эрх зүйн таатай орчинг бүрдүүлэх, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлнэ.

**ТӨСВИЙН 2018 ОНД ОНЦЛОГ**

- Нийтийн биеийн тамираар хичээллэгчийн тоог хүн амын 47%-д хүргэнэ.
- Соёл урлагын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, 1000 хүнд ногдох соёлын төвийн суудлын тоог 350-д хүргэнэ.
- Аялал жуулчлалын өрсөлдөх чадварыг бүс нутгийн хэмжээнд дээшлүүлнэ.
- Жилд хүлээн авах гадаадын жуулчны тоог 600 мянгад хүргэнэ.

**149.2 тэрбум**

| | 2018 (тэрбум) | 2017 оноос |
|---|---|---|
| Биеийн тамир спорт | 45.0 | 44.0% |
| Соёл урлаг | 102.7 | 33.1% |
| Аялал жуулчлал | 1.5 | 14.4% |

тэрбум төгрөг

Хөрөнгийн зардал 51.2

Урсгал зардал 98.0

- Цалин, НДШ 48.1
- Бараа үйлчилгээ 44.1
- Урсгал шилжүүлэг 5.9

## ЗАРДЛЫН ӨӨРЧЛӨЛТ

**Нийтийн биеийн тамирыг дэмжих**

**2.0** тэрбум — Спортыг дэмжих сангийн нийтийн биеийн тамирын арга хэмжээнд

**Үйл ажиллагаа өргөжсөнтэй холбоотой**

**1.6** тэрбум — Шинээр 4 усан бассейн, спорт цогцолбор, аймгийн театр, 1 сумын соёлын төв, 1 орон нутгийн музейн байр ашиглалтанд оруулах зардал

**Хувь хүнд олгох дэмжлэг, урамшуулал**

**0.2** тэрбум — 2017 онд дэлхийн аварга шалгаруулах тэмцээнээс медаль хүртсэн тамирчдад олгох урамшуулал

**Аялал жуулчлал**

**0.2** тэрбум — Улаанбаатар орчимд явган аяллын маршрутыг тохижуулахад

**Хөрөнгө оруулалт**

**33.0** тэрбум — Спорт, соёл урлагын салбарын хөрөнгө оруулалтын зардлын өсөлт

| Спорт, соёл урлагын салбарийн хөрөнгө оруулалт (барилга, байгууламжийн тоо) | |
|---|---|
| Соёлын өвийн төв | 1 |
| Үндэсний номын сангийн барилга | 1 |
| Хөгжимт драмын театр | 3 |
| Баруун Монголын соёлын төвийн барилга | 1 |
| Соёл, спортын цогцолбор | 2 |
| Соёлын төвийн их засвар | 10 |
| Соёлын төвийн барилга | 30 |
| Спорт цогцолбор | 8 |
| Спорт заал | 5 |
| Сагсны талбай | 3 |
| Оюуны спортын ордны барилга | 1 |

# ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН ХАМГААЛАЛ

Байгалийн унаган төрх, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалж, хойч үедээ өвлүүлэн үлдээх, байгалийн нөөц баялгийг хамгаалах, хомсдолоос сэргийлэх, зохистой ашиглах, нөхөн сэргээх боломжийг бүрдүүлэх, агаарын бохирдлыг бууруулах үйл ажиллагаа энэ хөтөлбөрт хамрагдаж байна.

## ТӨСВИЙН 2018 ОНД ОНЦЛОГ

- Агаарын бохирдлыг бууруулна.
- Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг өргөжүүлнэ.
- Ойг нөхөн сэргээх, түймэр, хөнөөлт шавжаас хамгаалах, ойн тогтвортой менежментийг хөгжүүлнэ.
- Орчны бохирдлыг бууруулахад иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлнэ.

**109.0 тэрбум**

| | 2018 (тэрбум) | 2017 оноос |
|---|---|---|
| Ойжуулалт | 11.9 | ▲10.6% |
| Усны нөөц, нуур, гол мөрний менежмент | 3.1 | ▲4.7% |
| Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалт | 6.5 | ▼0.4% |
| Агаарын бохирдлыг бууруулах, уур амьсгалын өөрчлөлт | 17.5 | ▲220.0% |
| Ус цаг уур, орчны шинжилгээ | 22.4 | ▲1.6% |
| Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага | 15.4 | ▲17.2% |
| Хүрээлэн буй орчны судалгаа шинжилгээ | 1.4 | ▲45.6% |
| Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх | 30.8 | ▲42.3% |

тэрбум төгрөг

Хөрөнгийн зардал 20.7

| Урсгал зардал | 88.3 |
|---|---|
| - Цалин, НДШ | 35.0 |
| - Бараа үйлчилгээ | 43.2 |
| - Татаас | 8.3 |
| - Урсгал шилжүүлэг | 1.8 |

## ЗАРДЛЫН ӨӨРЧЛӨЛТ

### Ойжуулалт, нөхөн сэргээлт

**1.0** тэрбум — Ойн хөнөөлт шавж устгах арга хэмжээний зардлын өсөлт

### Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага

**0.1** тэрбум — Сав газрын захиргааны байгууллагуудын зардлын өсөлт

**9.1** тэрбум — Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын өсөлттэй уялдуулан байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх зардлын өсөлт

### Ус цаг уур, орчны шинжилгээ

**0.4** тэрбум — Хур тунадас нэмэгдүүлэх бороомы пуужин болон газрын генераторын түлшний зардлын өсөлт

**0.2** тэрбум — Хөшигтийн хөндийн шинэ нисэх буудал ашиглалтад орохтой холбогдуулан нислэгийн цаг уурын төвийн орон тоо нэмэгдэхтэй холбоотой зардал

## АГААРЫН БОХИРДЛЫН ЭСРЭГ АРГА ХЭМЖЭЭ

**Агаарын бохирдлын эсрэг арга хэмжээнд нийт 137.9 тэрбум төгрөг төсөвлөв**

### Иргэдийн эрүүл мэндэд

**Уушгины хатгаа өвчний дархлаажуулалтын вакцин 1.0 тэрбум**

- Нийслэлийн 9 дүүргийн 35,000 гаруй нярай хүүхдийг үнэгүй хамруулах

### Дэд бүтцийг сайжруулах

**Цахилгаан дамжуулах агаарын шугамын ачааллыг бууруулах 2.9 тэрбум**

- Хэт ачаалагдсан дэд станцын чадлыг нэмэх
- Цахилгаан дамжуулах агаарын шугамын хүчин чадлыг өргөтгөх

**Агаарын чанарын 4 мэдээллийн төв байгуулах 0.6 тэрбум**

- Техник, технологийг олон нийтэд сурталчлах, борлуулах, сургалт зохион байгуулах

### Иргэдийг орон сууцаар хангах

**Орон сууцны ипотекийн зээл 120 тэрбум**

- Иргэдийг орон сууцжуулах ажлын хүрээнд Засгийн газраас хэрэгжүүлэх ипотекийн зээл

### Бохирдол ихтэй бүсийн утааг багасгах

**Шөнийн эрчим хүчний үнийн урамшуулал 8.3 тэрбум**

- Нийслэлд 2 тарифт тоолууртай гэр хорооллын 115,826 өрхийг 100% хөнгөлөх
- 10,000-аас дээш хүн амтай сумдын өрхийг 50% хөнгөлөх

**Агаарын бохирдол хэт өндөр бүсийн зорилтот өрхийг дэмжих 5.1 тэрбум**

- Хагас коксжсон 80,000 тонн түлшинд үнийн хөнгөлөлт
- Цахилгаан халаагуур 5,000 ширхэгийг үнэгүй олгоно.
- Сайжруулсан зуух 570 ширхэгийг үнэгүй олгоно.
- Боловсруулсан түлш 1,000 тонныг үнэгүй олгоно.



# ХҮҮХДИЙГ ТӨРӨӨС ХЭРХЭН АНХААРДАГ ВЭ?




Монгол Улсын 18 хүртэлх насны хүүхдийн тоо **1,105,128**

Эрэгтэй
**564,883**

Эмэгтэй
**540,245**

**86.1%**
Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт

**98.8%**
Хамран сургалтын бохир жин (1-9-р анги)

Хагас өнчин хүүхдийн тоо
**33,319**

Бүтэн өнчин хүүхдийн тоо
**3,383**

**98.7%**
0-1 хүртэлх насны хүүхдийн өргөн дархлаажуулалтад хамрагдалтын дундаж хувь

**15.2%**
Хүүхдийн хөдөлмөр эрхлэлт (5-17 насны хүүхдэд эзлэх хувь)

## ЭХ ХҮНИЙГ ТӨРӨӨС ХЭРХЭН АНХААРДАГ ВЭ?




**1,615,500** эмэгтэй
Нийт хүн амын 50.8%-ыг эзэлж байна

**585,700** эмэгтэй
Ажил эрхэлж байгаа нь нийт эмэгтэйчүүдийн 36.2% байна

**2-3** хүүхэд
Эмэгтэйчүүд дунджаар төрүүлж, өсгөдөг

**323,100** эмэгтэй
Дээд боловсролтой буюу 5 эмэгтэй тутмын 1 нь байна.

**846,100** төгрөг
Эмэгтэйчүүдийн сарын дундаж орлого

**77,544** эмэгтэй
Өрх толгойлж байгаа нь нийт эмэгтэйчүүдийн 4.8%-ийг эзэлж байна.

# ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭНИЙГ ТӨРӨӨС ХЭРХЭН АНХААРДАГ ВЭ?

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ТОО

Нийт **103,630**

Эрэгтэй **57,310**

Эмэгтэй **46,320**

## ТАНЫГ СУРАХАД

**Харааны бэрхшээлтэй иргэнд:**

- Брайл үсгэн материал, техник, тоног төхөөрөмжийг **үнэгүй тээвэрлэнэ**.
- 18 насанд хүрсэн бүрэн хараагүй, сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй иргэний утасны зардалд **20,000 төгрөг сар бүр** олгоно.
- Харааны бэрхшээлтэй иргэний ном, сурах бичиг хэвлэх зардлыг нийгмийн халамжийн сангаас **жилд нэг удаа**

## ТАНЫ ОРОН СУУЦАНД

**Жилд 1 удаа 140,000 төгрөг**

Орон сууцны хөлсөнд, нийтийн халаалтгүй бол түлш худалдан авахад зориулж (Үүнд. Бүрэн хараагүй, хэлгүй дүлий, хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан хүн, одой иргэн, байнгын асаргаа шаардлагатай 16 хүртэлх насны хүүхэд хамрагдана)

## ТАНЫ АМЖИЛТЫГ ҮНЭЛЖ

**Нэг удаагийн мөнгөн тэтгэмж**

Олимп, тивийн наадам, дэлхийн зэрэглэлийн тэмцээнд оролцож алт, мөнгө, хүрэл медаль хүртсэн тохиолдолд олгоно.

## ТАНЫГ СУВИЛАХ, АМРАХАД

- Рашаан сувиллын зардлын **50%**, нэг талын унааны зардлын **50% жилд 1 удаа**
- Хүүхдийн зусланд амрах эрхийн бичгийн **50%-ийг жилд 1 удаа**
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд эмнэлгийн магадлагаагаар дотоодод усан эмчилгээ хийлгэхэд **төлбөрийн 70%.**

## ОРТОПЕД, ПРОТЕЗИЙН ЗАРДАЛД

**Үнийг 100% нөхөж олгоно**

Дотоодод хийлгэсэн протез

- Хүүхдэд таарахгүй болсон тохиолдол бүрт
- ҮОМШӨ даатгалд хамрагдаагүй иргэнд **3 жилд 1 удаа**

Ортопед, тэргэнцэр зэрэг тусгай хэрэгслийн үнийг **3 жилд 1 удаа**

## БУСАД ЗАРДАЛД

**Оршуулгын тэтгэмж 1,000,000 төгрөг**

Хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон хүүхэд нас барахад оршуулгын зардалд

## ТАНЫГ АСАРЧ БУЙ ХҮНД

- Тэжээн тэтгэх үр хүүхэд, төрөл садангүй ганц бие болон,
- Эмнэлгийн хяналтанд байдаг, байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй иргэн эсвэл хүүхдийг асарч байгаа хүнд **сар бүр 70,000 төгрөг**
- Цэцэрлэг, сургуульд хүргэх унааны зардалд жилд **нэг удаа 200,000 төгрөг** олгоно.

## ТАНЫ ТЭЭВРИЙН ЗАРДАЛД

- Нийтийн тээврээр **үнэ төлбөргүй** зорчино.
- Дотоодын рашаан сувилалд сувилуулбал **нэг талын унааны зардлын 50%**,
- Бүрэн хараагүй иргэн эмчилгээ хийлгэхээр зорчих шаардлагатай бол **хоёр талын унааны зардлын 75%**,
- 1000 км дээш алслагдсан газраас эмчийн заавраар эмчилгээ хийлгэхээр Улаанбаатарт ирэх нэг талын **замын зардлыг 100% жилд 1 удаа** тус тус нөхөн олгоно.

# АХМАД НАСТАНГ ТӨРӨӨС ХЭРХЭН АНХААРДАГ ВЭ?

**АХМАД**

### ТАНЫГ ХАЛАМЖЛАН ТЭТГЭХЭД

**Улсаас таны**
- Эрүүл мэндийн даатгалыг хариуцдаг тул үнэ төлбөргүй эмнэлгийн тусламж үйлчилгээ авна.
- Өндөр насны тэтгэврийг нийгмийн даатгалаас олгодог.
- Нийгмийн даатгалаас тэтгэвэр авах эрх үүсээгүй бол нийгмийн халамжаас тэтгэвэр авдаг.

### НАСНЫ ХИШИГ

**Насны хишиг жилд 2 удаа**
- 65-69 нас: 50,000 төгрөг
- 70-79нас: 80.000 төгрөг
- 80-89 нас: 150.000 төргөг
- 90-с дээш: 250.000 төгрөг

### ТАНЫГ АСАРЧ БУЙ ХҮНД

**Сар бүр 70,000 төгрөг**
- Үр хүүхэд, төрөл садангийн хүнгүй ганц бие ахмадыг асрамжилж байгаа;
- Эмнэлгийн хяналтанд байдаг, байнгын асаргаа шаардлагатай ахмад настанг асарч байгаа иргэнд

### ТАНЫ ОРОН СУУЦАНД

**Жилд 1 удаа 140,000 төгрөг**
- Орон сууцны хөлсөнд, нийтийн халаалтгүй бол түлш худалдан авахад зориулж (тэжээн тэтгэх хүнгүй, хүндэт донор, төрийн өндөр алба хашиж байсан ахмадад)
- Онцгой гавъяатай ахмад настанд* **280,000 төгрөг** олгодог.

### АХМАДЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

**2018 онд 1.5 тэрбум төгрөг**
- Орон нутгийн ахмад настны кабинет болон ахмадын байгууллагын зардалд олгоно.



Ахмад настан гэж:
- 55 болон түүнээс дээш настай эмэгтэй
- 60 болон түүнээс дээш настай эрэгтэй

Нийт ахмад настны тоо: **273,468**

Хүн амын дундаж наслалт: **69.57**

### ТАНЫГ СУВИЛАХ, АМРАХАД

- Амралт, сувиллын газар амрахад **10 хоногт 200,000** төгрөгийн хөнгөлөлт **жилд 1 удаа**,
- Онцгой гавъяатай ахмад настан болон хүндэт донор рашаан сувилал болон **ирж, буцах унааны зардлыг 100% жилд 1 удаа** нөхөн олгоно
- Дотоодын рашаан **сувиллын зардлын 50%, нэг талын унааны зардлын 50% жилд нэг удаа** (эмнэлгийн дүгнэлт бүхий ахмад настан)

### ПРОТЕЗ, ОРТОПЕДИЙН ЗАРДАЛД

- Хөл, гарны протезийн хэрэгсэл **5 жил тутамд 1 удаа үнэгүй**
- Сонсох, харах эрхтний ортопедийн хэрэгслийг худалдан авсан болон дотоодод хийлгэсэн зардлыг **5 жил тутамд 1 удаа үнэгүй**
- Шүдний протезийн хэрэгсэл **3 жил тутамд 1 удаа үнэгүй**

### НАСТАН

### ТАНЫ ГАВЪЯАГ ҮНЭЛЖ

**Сар бүр 200,000 төгрөг**

- Ахмад дайчинд эсвэл дайнд амь эрсэдсэн бол эхнэр / нөхөрт нь

**Сар бүр 150,000 төгрөг**

- Онцгой гавъяатай ахмад* настанд

### БУСАД ЗАРДАЛД

**Оршуулгын тэтгэмж**

Ахмад настан нас барахад оршуулгын тэтгэмжийн зардалд **1,000,000 төгрөг** олгодог.

### ТАНЫ ТЭЭВРИЙН ЗАРДАЛД

- Нийслэл, аймгийн төвийн нийтийн тээврээр үнэ төлбөргүй зорчино. Үүнд 2018 онд 19.9 тэрбум төгрөг төсөвлөсөн.
- 1000 км дээш алслагдсан газраас эмчилгээ хийлгэхээр Улаанбаатарт ирэх **нэг талын унааны зардлыг жилд 1 удаа** тус тус нөхөн олгоно.

* ОНЦГОЙ ГАВЬЯАТАЙ АХМАД НАСТАН

Монгол Улсын баатар, хөдөлмөрийн баатар, ардын болон гавьяат цолтон, төрийн шагнал, төрийн соёрхолт, ахмад дайчин, улсын ударник, хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтэн, Монгол Улсын Үндсэн хуулийг хэлэлцэж, баталсан (1990-1992 он) Ардын Их Хурлын депутат, Улсын Бага Хурлын гишүүн ахмад настанг оруулсан болно.

# БҮЛЭГ 5. ОРОН НУТГИЙН ТӨСӨВ

## ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН БҮРДЭЛТ

Төсвийн тухай хуулиар аймаг, нийслэл ба сум дүүрэгт ногдох орлогыг тусгайлан зааж өгсөн байдаг. Ингэхдээ Татварын ерөнхий хуульд заасны дагуу тухайн шатны Иргэдийн төлөөлөгчдийн хурал нь татвар, хураамжийн хувь хэмжээг Улсын Их Хурлаас баталсан хязгаарт багтаан тогтоох эрхтэй юм. Улсын төсвөөс орон нутгийн суурь тэнцлийг тооцохдоо татварыг доод хувь хэмжээгээр тооцдог бөгөөд орон нутаг нь дээрх хувь хэмжээг нэмэгдүүлэн орон нутгийн орлогоо нэмэгдүүлэх боломжтой байдаг.

**Орон нутгийн төсвийн эх үүсвэр**

| | | АЙМАГ, НИЙСЛЭЛ | СУМ, ДҮҮРЭГ |
|---|---|---|---|
| ТАТВАРЫН ОРЛОГО | Албан татвар | Нийслэл хотын | Нохойны |
| | | Үл хөдлөх хөрөнгийн | Галт зэвсгийн |
| | | Автотээвэр, өөрөө явагч хэрэгслийн | Орлогыг нь тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ эрхлэгч хувь хүний орлогын |
| | | Өв залгамжлал, бэлэглэлийн | |
| | | Цалин, түүнтэй адилтгах орлогын ХХОАТ | Цалин, түүнтэй адилтгах орлогоос бусад орлогын ХХОАТ |
| | Төлбөр | Газрын | Түгээмэл тархацтай ашигт малтмал, агнуурын нөөц ашигласны |
| | | Үйлдвэрлэл, үйлчилгээнд ашигласан усны | Ой мод, ургамал, ус, рашаан ашигласны |
| | | Газрын тосны хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийн аймаг, нийслэлд 20%, сум, дүүрэгт 10% | |
| | Хураамж | Улсын тэмдэгтийн | |
| | | | Хог хаягдлын үйлчилгээний |
| | | | Ашигт малтмалаас бусад байгалийн баялаг ашиглах зөвшөөрлийн |
| | | | Ан амьтан агнах, барих зөвшөөрлийн |
| ТАТВАРЫН БУС ОРЛОГО | | Орон нутгийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг | |
| | | Орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр болон борлуулсны орлого, хүү, торгуулийн орлого | |
| | | Хууль тогтоомжийн дагуу орон нутгийн төсөвт төвлөрүүлэх, сум дүүргийн төсөвт орох бусад орлого | |



## ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЦУУЛАЛТ

Төсвийн тухай хуулиар орон нутгийн төсвөөр хэрэгжүүлэх чиг үүргийг аймаг, нийслэл, сум, дүүрэг тус бүрээр зааж өгсөн байдаг. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр тухайн орон нутгийн удирдлагыг хэрэгжүүлэх, нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлэх, дэд бүтэц, орон сууц, нийтийн аж ахуйн үйлчилгээ үзүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, бэлчээрийн менежмент, мал эмнэлгийн үйлчилгээ, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр заасан байна.



**Орон нутгийн төсвөөр хэрэгжүүлэх чиг үүрэг**

| СУМ, ДҮҮРЭГ | АЙМАГ, НИЙСЛЭЛ | |
|---|---|---|
| Нутгийн удирдлагын үйл ажиллагааны зардал | | **Удирдлага, нийтийн үйлчилгээ** |
| Тохижилт, орон сууц, нийтийн аж ахуйн үйлчилгээ, ариун цэвэр, цэвэрлэгээ, хог зайлуулалт | | |
| Гудамж талбайн гэрэлтүүлэг, урсгал засвар, арчилгаа | | |
| Тохижилт, мод, ургамал, цэцэрлэгжүүлэлт, явган зам хийх | Нийтийн тээврийн үйлчилгээ | |
| Амралтын болон хүүхдийн тоглоомын талбайн тохижуулалт | Цахилгаан түгээлтийн хэвийн үйл ажиллагаа | |
| Барилга байгууламжийн их засвар, шинээр өмч бий болгох, хөрөнгө оруулалт | | **Дэд бүтэц** |
| Усан хангамж, бохир ус цэвэрлэх байгууламж бий болгох, усны аж ахуйн хөнгөлөлт, үйлчилгээ | | |
| | Авто зам, гүүр, гэрэлтүүлэг, гэрлэн дохио, бусад байгууламж | |
| Нийгмийн асрамж, халамжийн үйлчилгээ үзүүлэх, зохион байгуулах | | |
| | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ядуурлыг бууруулах хөтөлбөр, арга хэмжээ | **Хөдөлмөр эрхлэлт** |
| | Жижиг, дунд үйлдвэрлэл | |
| Эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх | Бэлчээрийн менежмент, малын тэжээлийн нөөц | **Хөдөө аж ахуй** |
| Мал амьтны халдварт өвчин | | |
| Мал эмнэлгийн үйлчилгээ | | |
| Гамшгаас урьдчилан сэргийлэх | | **Байгаль орчин, гамшиг** |
| Гамшгийн хор хохирлыг арилгах | Үерийн хамгаалалтыг зохион байгуулах | |
| Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх | | |
| Хортон шавжийн устгал, хяналтыг хэрэгжүүлэх | | |

## УЛС, ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХАРИЛЦАА

Орон нутгийн төсөв бол иргэдэд хамгийн ойр байдаг төсөв бөгөөд аймаг, нийслэл, сум, дүүрэг хуулиар заасан өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай арга хэмжээг санхүүжүүлэх эх үүсвэр болон зарцуулалтыг заасан төлөвлөгөө юм.

Орон нутгийн төсөв нь аймаг, нийслэл, сум, дүүргийн төсвөөс бүрдэнэ.
Аймаг, нийслэлийн төсвийн дээд шатны төсөв нь улсын төсөв, сум дүүргийн төсвийн дээд шатны төсөв нь аймаг, нийслэлийн төсөв байна.




**Суурь орлого** – Тухайн шатны төсөвт орох татварын доод хувь хэмжээгээр тооцсон орлого болон татварын бус орлогын нийлбэр

**Суурь зарлага** – Орон нутгийн засаг захиргааны нэгжийн удирдлагын зардал, нийгмийн халамж, байгаль орчныг хамгаалахтай холбогдох зардал

**1. Тусгай зориулалтын шилжүүлэг:** Аймаг, нийслэлийн Засаг дарга Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлдэг. Эдгээр чиг үүргүүдийг гэрээний үндсэн дээр улсын төсвөөс олгох тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжүүлнэ. Гэрээг тухайн шатны төсөв батлагдсанаас 14 хоногийн дотор байгуулна.
**2. Санхүүгийн дэмжлэг:** Орон нутгийн төсвийн суурь зарлага нь суурь орлогоос их буюу алдагдалтай бол улсын төсвөөс санхүүгийн дэмжлэг олгоно.
**3. Төвлөрүүлэх орлого:** Орон нутгийн төсвийн суурь орлого нь суурь зардлаас их буюу ашигтай гарвал тухайн ашгаас нь тодорхой хувиар улсын төсөвт төвлөрүүлнэ.

# ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САН

Орон нутгийн хөгжлийн сан бол иргэдийн саналаар шийдэж зарцуулах төсөв юм. Тус сан нь засаг захиргааны нэгжүүд өөрсдийн хэрэгцээнд суурилсан хөрөнгө оруулалтын хөтөлбөрүүд болон бие даан хэрэгжүүлэх ёстой чиг үүргүүдээ санхүүжүүлэх боломж бүрдүүлдгээрээ давуу талтай юм.

2018 оны хувьд дотоодын нэмэгдсэн өртгийн албан татварын 5%, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн 5%, газрын тосны нөөц ашигласны төлбөрийн 30%, олон улсын байгууллагаас олгох урамшуулал, дэмжлэгийг нийлүүлээд нийт 88.6 тэрбум төгрөгийг санд хуваарилж байна.

Сангаас хүн амын тоо, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээ, орон нутгийн хөгжлийн индекс зэргийг харгалзсан томьёогоор аймаг нийслэл бүрт ногдох шилжүүлгийг хуваарилна. Аймаг нийслэл өөрт ногдох хэсгээ үлдээж, 30%-иас доошгүй сум, дүүрэгтээ мөн ижил үзүүлэлт бүхий томьёо ашиглан шилжүүлэх ёстой.

**Орон нутгийн хөгжлийн сангийн хуваарилалт, аймгаар (тэрбум төгрөг)**




Тухайн орон нутгийн иргэд олон нийтийн бодит хэрэгцээ шаардлагад нийцсэн, мөн тэдний санал санаачилгаар дэмжигдсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр төсөл арга хэмжээнд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг зарцуулах бөгөөд тухайн орон нутгийн иргэдийн нийтийн хурал, ИТХ-ын шийдвэрээр баталгаажиж төсөвт тусгагдах ёстой.

**Орон нутгийн хөгжлийн сан дахь иргэдийн оролцоо**



## НИЙСЛЭЛИЙН 2018 ОНЫ ТӨСӨВ

Нийслэл, дүүргийн 2018 оны төсвийн нийт орлого 828.5 тэрбум төгрөг, нийт зардал 620.0 тэрбум төгрөг, улсын төсөвт төвлөрүүлэх орлогын дүн 208.5 тэрбум төгрөг байна. Үүнээс гадна, Засгийн газрын зарим чиг үүрэг нийслэлд хэрэгжүүлэхтэй холбоотойгоор тусгай зориулалтын шилжүүлгээр нийт 354.5 тэрбум төгрөг, орон нутгийн хөгжлийн сангийн хуваарилалтаар 16.3 тэрбум төгрөг тус тус нийслэлд зарцуулагдана.

Төсвийн орлогын бүрдүүлэлтийг хот, дүүргээр нь ангилан авч үзвэл, хотын шуудын төсөвт 630.7 тэрбум төгрөгийн орлого төвлөрч, нийслэлийн төсвийн орлогын 76.1%-ийг бүрдүүлэхээр, дүүргүүдийн төсөвт 197.8 тэрбум төгрөгийн орлого төвлөрч, нийслэлийн төсвийн орлогын 23.9%-ийг тус тус бүрдүүлэхээр байна.



Нийслэл, дүүргийн төсвийн орлого нийт 23 нэр төрлийн татварын болон татварын бус орлогоос бүрдэж, нийт орлогын дийлэнх буюу 66%-ийг хувь хүний орлогын албан татвараас бүрдүүлж, үлдсэн нь үл хөдлөх хөрөнгө, автотээвэр болон өөрөө явагч хэрэгслийн татвар, авто зам ашигласны төлбөр, хүү торгуулийн орлого зэргээс бүрдэж байна.

Харин нийт зарлагын 73.4% буюу 455.1 тэрбум төгрөг нь урсгал зардал бөгөөд үүний 337.6 тэрбум төгрөг нь хотын шууд харъяалагдах үйл ажиллагааны урсгал зардал, 117.5 тэрбум төгрөг нь 9 дүүргийн урсгал зардал байна.
Нийслэл, дүүргийн төсвийн нийт орлого болон зарлагыг доорх зурагт ангилан харууллаа.



## НИЙСЛЭЛИЙН ТӨСВИЙН УРСГАЛ ЗАРДАЛ

Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлд заасан нийслэл бие даан хэрэгжүүлэх 18 чиг үүргийн дагуу нийслэлийн төсвийн урсгал зардлыг төлөвлөн, зарцуулж байна. 2018 онд урсгал зардалд нийт 455.1 тэрбум төгрөг батлагдсан нь нийслэлийн төсвийн байгууллагын үйл ажиллагаа, халамж, нийтийн тээвэр, хот тохижилт болон бусад зардалд зарцуулагдахаар байна. Үүнийг дэлгэрэнгүй харуулбал:

### НИЙТ УРСГАЛ ЗАРДАЛ (455.1 тэрбум төгрөг)




#### Нийслэлийн төсвийн байгууллагын үйл ажиллагааны зардал

**116.5** ▲ 5.5% 2017 оноос



25.5%

| Зардлын төрөл | 2018 он (тэрбум төгрөг) | Эзлэх хувь |
|---|---|---|
| Цалин, НДШ | 52.0 | 44.7% |
| Байр ашиглалтын | 11.1 | 9.5% |
| Бараа үйлчилгээ болон бусад | 53.4 | 45.8% |

#### Нийгмийн халамжийн сан

**107.6** ▲ 6.0% 2017 оноос



23.6%

| Зардлын төрөл | 2018 он (тэрбум төгрөг) | Эзлэх хувь |
|---|---|---|
| Халамжийн тэтгэвэр | 39.3 | 36.5% |
| Хүнсний талон | 16.8 | 15.6% |
| Ахмад настны халамж үйлчилгээ | 10.6 | 9.8% |
| Жирэмсэн, хөхүүл эхийн тэтгэмж | 9.0 | 8.4% |
| Амьжиргаа дэмжих тэтгэмж | 8.9 | 8.3% |
| ХБИ-ийн халамж үйлчилгээ | 6.5 | 6.0% |
| Олон нийтийн оролцоо халамжийн үйлчилгээ | 1.1 | 1.0% |
| Бусад | 15.4 | 14.3% |

#### Нийтийн тээврийн нөхөн олговрын зардал

**89.9** ▲ 5.1% 2017 оноос



19.8%

| Зардлын төрөл | 2018 он (тэрбум төгрөг) | Эзлэх хувь |
|---|---|---|
| Оюутан үнэгүй зорчих | 7.3 | 8.1% |
| МСҮТ-ийн суралцагч үнэгүй зорчих | 1.4 | 1.6% |
| Цагдаагийн албан хаагч үнэгүй зорчих | 1.4 | 1.6% |
| Ахмад настан үнэгүй зорчих | 19.1 | 21.2% |
| Хөгжлийн бэрхшээлтэй иргэн үнэгүй зорчих | 6.7 | 7.5% |
| Нийтийн тээврийн үйлчилгээний нэмэлт зардал | 54.0 | 60.1% |

#### Хот тохижуулах зардал

**87.7** ▲ 14.7% 2017 оноос



19.3%

| Зардлын төрөл | 2018 он (тэрбум төгрөг) | Эзлэх хувь |
|---|---|---|
| Хог хаягдал тээвэрлэх | 27.2 | 31.0% |
| Нийтийн зам талбайн цэвэрлэгээ | 23.4 | 26.7% |
| Цэцэрлэгжүүлэлт | 11.5 | 13.1% |
| Гэрэлтүүлэг, урсгал засвар | 9.6 | 10.9% |
| Камерын ашиглалт, арчлалт | 0.7 | 0.8% |
| Нийтийн зам талбайн арчилгаа, засвар | 15.3 | 17.4% |

## Бусад зардлууд

**53.4** ▲ 25.1% 2017 оноос




| Зардлын төрөл | 2018 он (тэрбум төгрөг) | Өсөлт (2017 оноос) |
|---|---|---|
| Засаг даргын нөөц хөрөнгө | 9.6 | ▼ 1.3% |
| Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардал | 6.2 | ▼ 13.4% |
| Газрын хянан баталгаажуулах зардал | 1.1 | ▲ 0% |
| Замын хөдөлгөөн зохицуулах гэрээт хэлтсийн үйл ажиллагааны зардал | 1.6 | ▼ 2.8% |
| Жолоочийн хариуцлагын даатгалын сангийн шилжүүлэг | 2.7 | ▼ 39.0% |
| Нийслэлд хэрэгжих хөтөлбөр | 16.1 | ▼ 1.0% |
| Бичил зээл, жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан | 16.0 | ▲ 606.8% |




## НИЙСЛЭЛИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Нийслэлийн төсвөөр хийгдэж буй хөрөнгө оруулалт нь хотын оршин суугчдад боловсрол, эрүүл мэнд, төрийн үйлчилгээг саадгүй хүргэх, иргэдийн тав тухтай орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлэхэд чиглэдэг. 2018 онд нийт 181.1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын ажлыг төлөвлөсөн. Үүнийг нийслэл, дүүргийн төсвөөр 128.0 тэрбум, нийслэлийн замын сангаас 36.9 тэрбум, нийслэлийн Орон нутгийн хөгжлийн сангаас 16.3 тэрбум төгрөгөөр санхүүжүүлнэ.

## НИЙТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

**164.9** ▼ 22.9% 2017 оноос



| Хөрөнгө оруулалтын хэлбэр | 2018 он (тэрбум төгрөг) | Өсөлт (2017 оноос) |
|---|---|---|
| Төрийн үйлчилгээг сайжруулах | 6.7 | ▼ 16.0% |
| Хот байгуулалт, дэд бүтцийн салбарт | 82.8 | ▼ 29.4% |
| Нийгмийн салбарт | 24.6 | ▼ 10.9% |
| Авто замын салбарт | 36.9 | ▼ 12.4% |
| Хот, нийтийн аж ахуйн салбарт | 8.9 | ▼ 25.4% |
| Нийтийн тээврийн салбарт | 1.0 | ▼ 66.7% |
| Байгаль орчныг хамгаалах | 4.0 | ▼ 54.5% |

Нийслэлийн төсвийг боловсруулахад 2014 оноос эхлэн олон нийтийн санал авч байна.

- "Нийслэлийн Иргэний танхим"-д нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулах
- Ulaanbaatar.mn цахим хуудсаар санал асуулга
- Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төвийн 4 салбараар дамжуулан авдаг.

2018 оны төсвийн хэлэлцүүлэгт 9 дүүргийн нийт 300-аад иргэд оролцож, нийт 972 санал хүсэлтийг ирүүлсэн.

**ТОП - 5 хөтөлбөр**

**972 санал**

| Санал | Хөтөлбөр |
|---|---|
| 120 | Гэр хорооллын дахин төлөвлөлт |
| 112 | Зам талбайн тохижилт |
| 98 | Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх |
| 95 | Авто зам барих, засварлах |
| 78 | Гэр хорооллын цахилгаан хангамж |

## НИЙСЛЭЛ, ДҮҮРГИЙН ТӨСВИЙН ХАРИЛЦАА

Нийслэлийн төсөв нь хотын шууд болон есөн дүүргийн төсвөөс бүрдэнэ. Хотын шуудын төсөв нь дүүргийн төсвийн дээд шатны төсөв бөгөөд Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар батлагдана.

Ингэхдээ төсвийн суурь тэнцэл алдагдалтай дүүрэгт санхүүгийн дэмжлэг өгөх бөгөөд харин ашигтай дүүргээс орлого төвлөрүүлдэг. 2018 оны төсвийн жилд Сонгинохайрхан, Налайх, Багануур, Багахангай дүүргүүдэд нийт 15.0 тэрбум төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгох бол Сүхбаатар, Чингэлтэй, Баянгол, Баянзүрх, Хан-Уул дүүргүүдээс нийт 83.5 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлнэ.

Дүүргийн төсвийг тухайн дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал батлах бөгөөд дүүргийн төсвийн эх үүсвэр болох зарим татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх замаар орлого болон зардлаа нэмэгдүүлэн батлах боломжтой. Мөн тусгай зориулалтын шилжүүлэг буюу сургууль, цэцэрлэг, өрхийн эмнэлэг, соёл урлагийн зардлыг байгууллага бүрээр хуваарилан баталдаг.

### НИЙСЛЭЛИЙН ТӨСӨВ (2018 он, тэрбум төгрөг)

| | |
|---|---|
| Орлого | 828.5 |
| Зарлага | 620.0 |
| Улсын төсөвт төвлөрүүлэх | 208.5 |
| Тусгай зориулалтын шилжүүлэг | 354.5 |
| Орон нутгийн хөгжлийн сан | 16.3 |

**ХОТЫН ШУУД**



## ХАВСРАЛТ 1. ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ НАРЫН ХОЛБОО БАРИХ ХАЯГ

| Төсвийн ерөнхийлөн захирагч | Цахим хуудас | Холбоо барих |
|---|---|---|
| Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга | www.president.mn | Утас: 51- 265003<br>Утас: 51- 263489 |
| Монгол Улсын Их Хурлын дарга | www.parliament.mn | Утас: 51-267016<br>Цахим шуудан: secretariat@parliament.mn |
| Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дарга | www.conscourt.gov.mn | Утас: 62-263761<br>Цахим шуудан: info@conscourt.gov.mn |
| Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч | www.supremecourt.mn | Утас: 62-261698<br>Цахим шуудан: info@supremecourt.mn |
| Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга | www.judcouncil.mn | Утас: 70008045<br>Цахим шуудан: contact@judcouncil.mn |
| Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга | www.mn-nhrc.org | Утас: 70000222, 51-262971, 51-262786<br>Цахим шуудан: info@mn-nhrc.org |
| Улсын ерөнхий прокурор | www.prokuror.mn | Утас: 51-264453<br>Цахим шуудан: gpo@prokuror.mn |
| Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга | www.nsc.gov.mn | Утас: 70113959<br>Цахим шуудан: info@nsc.gov.mn |
| Монгол Улсын Ерөнхий аудитор | www.audit.mn | Утас: 51-261585<br>Цахим шуудан: info@audit.gov.mn |
| Авлигатай тэмцэх газрын дарга | www.iaac.mn | Утас: 70110251, 11-311919, 1800-1969<br>Цахим шуудан: contact@iaac.mn |
| Санхүүгийн зохицуулах хорооны дарга | www.frc.mn | Утас: 51-264444<br>Цахим шуудан: webmaster@frc.mn |
| Төрийн албаны зөвлөлийн дарга | www.csc.gov.mn | Утас: 51-264216<br>Цахим шуудан: info@csc.gov.mn |
| Үндэсний статистикийн хорооны дарга | www.nso.mn | Утас: 11-321433, 1900-1212<br>Цахим шуудан: information@nso.mn |
| Сонгуулийн ерөнхий хорооны дарга | www.gec.gov.mn | Утас: 11-328383, 51-260975<br>Цахим шуудан: gecm@gec.gov.mn |
| Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын дарга | www.tsauzbuk.mn | Утас: 976-51-261725, 51261452<br>Факс:976-11-320178 |
| Монгол Улсын Ерөнхий сайд | www.cabinet.gov.mn | Утас: 51-260311<br>Факс: 11-310011 |
| Монгол Улсын Шадар сайд | www.cabinet.gov.mn | Утас: 51-260311<br>Факс: 11-310011 |
| Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга | www.cabinet.gov.mn | Утас: 51-260311<br>Факс: 11-310011 |
| Байгаль орчин, аялал жуулчлалын сайд | www.mne.mn | Утас:51-261966<br>Цахим шуудан: webmaster@mne.gov.mn |
| Гадаад харилцааны сайд | www.mfa.gov.mn | Утас: 62-262222<br>Цахим шуудан: info@mfa.gov.mn |

| Төсвийн ерөнхийлөн захирагч | Цахим хуудас | Холбоо барих |
|---|---|---|
| Сангийн сайд | www.mof.gov.mn | Утас: 51-267473<br>Цахим шуудан: info@mof.gov.mn |
| Хууль зүй, дотоод хэргийн сайд | www.mojha.gov.mn | Утас: 51-267533<br>Цахим шуудан: info@mojha.gov.mn |
| Зам, тээврийн хөгжлийн сайд | www.mrtd.gov.mn | Утас: 62-263179<br>Цахим шуудан: info@mrtd.gov.mn |
| Батлан хамгаалахын сайд | www.mod.gov.mn | Утас: 51-261636<br>Цахим шуудан: info@mod.gov.mn |
| Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд | www.mecss.gov.mn | Утас: 51- 263158<br>Цахим шуудан: Info@mecs.gov.mn |
| Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд | www.mmhi.gov.mn | Утас: 51-263506<br>Цахим шуудан: info@mmhi.gov.mn |
| Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд | www.mofa.gov.mn | Утас: 51-262271<br>Цахим хуудас: mofa@mofa.gov.mn |
| Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд | www.mlsp.gov.mn | Утас: 11-328634<br>Цахим хуудас: info@mlsp.gov.mn |
| Эрүүл мэндийн сайд | www.mohs.mn | Утас: 51-263695, 51-263913<br>Цахим шуудан: info@moh.gov.mn |
| Эрчим хүчний сайд | www.energy.gov.mn | Утас: 62-263051<br>Цахим шуудан: info@energy.gov.mn |
| Барилга, хот байгуулалтын сайд | www.mcud.gov.mn | Утас: 7600 3333<br>Цахим шуудан: info@mcud.gov.mn |

## ХАВСРАЛТ 2. АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ХОЛБОО БАРИХ ХАЯГ

| Аймаг | Цахим хуудас | Холбоо барих |
|---|---|---|
| Архангай | www.arkhangai.gov.mn | Утас: 7033-1111 |
| Баян-Өлгий | www.bayan-olgii.gov.mn | Утас: 7042-3264<br>Цахим шуудан: info@bayan-olgii.gov.mn |
| Баянхонгор | www.bayankhongor.gov.mn | Утас: 7044-0001, 7044-2616<br>Цахим шуудан: bayankhongorprovince@gmail.com |
| Булган | www.bulgan.gov.mn | Утас: 7034-1111<br>Цахим шуудан: info@bulgan.gov.mn |
| Говь-Алтай | www.govi-altai.gov.mn | Утас: 7048-3360<br>Цахим шуудан: info@govi-altai.gov.mn |
| Дорноговь | www.dornogovi.gov.mn | Утас: 7052-3036<br>Цахим шуудан: zdtg@dornogovi.gov.mn |
| Дорнод | www.dornod.gov.mn | Утас: 7058-4240, 7058-2879<br>Цахим шуудан: contact@dornod.gov.mn |
| Дундговь | www.dundgovi.gov.mn | Утас: 7059-2494<br>Цахим шуудан: info@dundgovi.gov.mn |
| Завхан | www.zavkhan.gov.mn | Утас: 7575-1155<br>Цахим шуудан: zavkhan@gov.mn |
| Өвөрхангай | www.uvurkhangai.mn | Утас: 7032-3990, 7032-3358<br>Цахим шуудан: uvurkhangai2010@gmail.com |
| Өмнөговь | www.omnogovi.gov.mn | Утас: 7053-0001<br>Цахим шуудан: info@omnogovi.gov.mn |
| Сүхбаатар | www.sukhbaatar.mn | Утас: 7051-8674<br>Цахим шуудан: |
| Сэлэнгэ | www.selenge.gov.mn | Утас: 7036-2171, 7036-1111<br>Цахим шуудан: azdtg@selenge.gov.mn |
| Төв | www.tov.gov.mn | Утас: 7027-1111<br>Цахим шуудан: info@tuv.gov.mn |
| Увс | www.uvs.gov.mn | Утас: 7045-2222<br>Цахим шуудан: info@uvs.gov.mn |
| Ховд | www.khovd.gov.mn | Утас: 7043-2402<br>Цахим шуудан: info@khovd.gov.mn |
| Хөвсгөл | www.khovsgol.gov.mn | Утас: 7038-1111<br>Цахим шуудан: info@khs.gov.mn |
| Хэнтий | www.khentii.mn | Утас: 7056-2401<br>Цахим шуудан: infoazdtg@khentii.gov.mn |
| Дархан-Уул | www.darkhan.gov.mn | Утас: 7037-7121<br>Цахим шуудан: info@darkhan.gov.mn |
| Орхон | www.erdenet.mn | Утас: 7035-9522<br>Цахим шуудан: government@erdenet.mn |
| Говьсүмбэр | www.govisumber.gov.mn | Утас: 7054-3434<br>Цахим шуудан: info@govisumber.gov.mn |
| Нийслэл | www.ulaanbaatar.mn | Утас: 11-328922<br>Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төв:<br>Утас: 7585-1200 |

## ХАВСРАЛТ 3. МЭДЭЭЛЛИЙН ЭХ СУРВАЛЖ

| Цахим хуудас | Тайлбар |
|---|---|
| www.mof.gov.mn | Сангийн яамны үндсэн цахим хуудас бөгөөд яамны бүтэц, бодлого, чиглэл, төсвийн талаарх мэдээ, мэдээлэл |
| www.iltod.gov.mn | Төсвийн тухай цаг үеийн мэдээ, мэдээлэл, жил бүрийн төсвийн мэдээлэл, төсвийн холбогдолтой хууль, тогтоол, заавар журам |
| www.shilendans.gov.mn | Бүх төсвийн байгууллага, төрийн өмчит үйлдвэрийн газруудын төсөв, түүний зарцуулалтын талаарх мэдээ мэдээлэл |
| www.tusuv-oronnutag.mof.gov.mn | Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл хөтөлбөрүүдийн мэдээлэл |
| www.e-balance.mof.gov.mn | Аж ахуйн тайлангийн нэгдсэн систем бөгөөд нягтлан бодох бүртгэлтэй холбоотой заавар, тушаал зөвлөгөө |
| www.audit.mn | Аудитын төлөвлөгөө, тайлан, зөвлөмж |
| www.tender.gov.mn | Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем |
| www.worldbank.org/mn/country/mongolia | Дэлхийн банкны Монгол Улсын талаар мэдээлэл бүхий цахим хуудас |
| www.imf.org/en/Countries/ResRep/MNG | Олон улсын валютын сангийн Монгол Улсын талаар мэдээлэл бүхий цахим хуудас |
| www.adb.org/countries/mongolia/main | Азийн хөгжлийн банкны Монгол Улсын талаар мэдээлэл бүхий цахим хуудас |
| www.1212.mn | Үндэсний статистикийн хорооны мэдээллийн нэгдсэн сан |
| www.internationalbudget.org | Интернэйшнэл Баджет Партнершип ТББ-ын цахим хуудас |

## ХАВСРАЛТ 4. ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА (2015-2018 он)

| Эдийн засгийн ангилал | 2015 | 2016 | 2017 | 2018 |
|---|---|---|---|---|
| | Гүйцэтгэл | Гүйцэтгэл | Батлагдсан | Батлагдсан |
| **НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН** | 5,983.4 | 5,835.0 | 7,112.9 | 7,862.9 |
| **ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН** | 0.0 | 0.0 | 242.4 | 122.7 |
| **ИРЭЭДҮЙН ӨВ САН** | 0.0 | 0.0 | 333.3 | 508.7 |
| **ТӨСВИЙН ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН** | 5,981.1 | 5,835.0 | 6,537.1 | 7,231.4 |
| **1. Татварын орлого** | 5,119.0 | 4,951.0 | 5,661.3 | 6,268.9 |
| 1.1. Орлогын албан татвар | 1,170.8 | 1,043.4 | 1,330.8 | 1,407.9 |
| 1.1.1 Хувь хүний орлогын албан татвар | 482.3 | 523.4 | 602.1 | 716.5 |
| 1.1.2 Аж, ахуйн нэгжийн орлогын албан татвар | 688.5 | 520.0 | 728.7 | 691.4 |
| 1.2. Нийгмийн даатгалын шимтгэл, хураамж | 1,018.2 | 1,109.8 | 1,248.5 | 1,431.1 |
| 1.3. Хөрөнгийн албан татвар | 86.6 | 104.7 | 98.6 | 111.2 |
| 1.4. Нэмэгдсэн өртгийн албан татвар | 1,049.6 | 1,140.7 | 1,448.5 | 1,517.3 |
| 1.5. Онцгой албан татвар | 592.3 | 630.1 | 511.6 | 684.3 |
| 1.6. Тусгай зориулалтын орлого | 11.8 | 10.8 | 11.9 | 12.1 |
| 1.7. Гаалийн албан татвар | 320.6 | 328.5 | 489.8 | 536.9 |
| 1.8. Бусад татвар (төлбөр, хураамж) | 869.1 | 583.1 | 521.6 | 568.2 |
| **2. Татварын бус орлого** | 862.1 | 884.1 | 875.8 | 962.5 |
| 2.1. Нийтлэг бус татварын орлого | 753.5 | 805.4 | 799.7 | 852.0 |
| 2.2. Хөрөнгийн орлого | 55.1 | 1.5 | 0.4 | 0.5 |
| 2.3. Тусламжийн орлого | 53.4 | 77.2 | 75.7 | 110.0 |
| **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 7,138.0 | 9,495.3 | 9,154.5 | 9,651.5 |
| **А. УРСГАЛ ЗАРЛАГА** | 5,718.4 | 6,613.8 | 7,001.6 | 7,455.9 |
| **1. Бараа, үйлчилгээний зардал** | 2,801.7 | 3,133.3 | 3,089.1 | 3,257.5 |
| 1.1. Цалин, хөлс | 1,709.8 | 1,746.8 | 1,766.8 | 1,797.1 |
| 1.3. Бараа, үйлчилгээний бусад зардал | 1,091.9 | 1,386.5 | 1,322.3 | 1,460.4 |
| **2. Зээлийн үйлчилгээний төлбөр** | 731.1 | 986.1 | 1,156.7 | 1,150.7 |
| **3. Татаас ба урсгал шилжүүлэг** | 2,185.6 | 2,494.4 | 2,755.8 | 3,047.6 |
| 3.1. Татаас | 101.5 | 229.3 | 199.3 | 233.9 |
| 3.2. Урсгал шилжүүлэг | 2,084.2 | 2,265.1 | 2,556.5 | 2,813.8 |
| **Б. ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | 1,396.7 | 2,360.2 | 1,813.5 | 1,928.5 |
| 1. Барилга байгууламж | 614.5 | 1,577.0 | 1,041.2 | 1,049.8 |
| 2. Их засвар | 110.8 | 129.0 | 77.9 | 72.2 |
| 3. Тоног төхөөрөмж | 73.8 | 0.0 | 99.7 | 292.6 |
| 4. Бусад хөрөнгө | 136.1 | 401.5 | 558.5 | 482.8 |
| 5. Стратегийн нөөц хөрөнгө | 27.8 | 0.0 | 36.3 | 31.2 |
| 6. Төсвөөс эргэн төлөгдөх хөрөнгө оруулалт | 433.7 | 252.8 | 0.0 | 0.0 |
| **В. ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ЦЭВЭР ЗЭЭЛ** | 22.9 | 521.3 | 339.4 | 267.2 |
| 1. Эргэж төлөгдөх дотоод цэвэр зээл | -17.6 | 487.6 | 145.8 | 145.9 |
| 2. Эргэж төлөгдөх гадаад цэвэр зээл | 40.5 | 33.8 | 193.6 | 121.2 |
| ТӨСВИЙН ТЭНЦЭЛ (тэнцвэржүүлсэн орлогоор тооцсон) | -1,156.9 | -3,660.3 | -2,617.4 | -2,420.1 |
| ТӨСВИЙН АЛДАГДАЛ (ДНБ-д эзлэх хувиар) | -5.0% | -15.3% | -9.5% | -8.0% |

## ХАВСРАЛТ 5. НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

| | | |
|---|---|---|
| Төсөвтэй холбоотой | Төсвийн орлого | Хууль тогтоомжийн дагуу улсын болон орон нутгийн төсөв бүрдүүлэх орлого болон төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогын бүрдэл; |
| Төсөвтэй холбоотой | Төсвийн зарлага | Төсөв захирагчийн үйл ажиллагаа, хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр батлагдсан төсвөөс хуваарилан, зарцуулах хөрөнгө; |
| Төсөвтэй холбоотой | Төсвийн тэнцэл | Тухайн төсвийн жилийн төсвийн нийт орлого, зарлагын зөрүү; |
| Төсөвтэй холбоотой | Төсвийн ашиг | Төсвийн зарлагаас давсан орлого; |
| Төсөвтэй холбоотой | Төсвийн алдагдал | Төсвийн орлогоос давсан зарлага; |
| Эдийн засагтай холбоотой | Дотоодын нийт бүтээгдэхүүн | Нэг жилийн хугацаанд Монгол Улсын нутаг дэвсгэрт үйлдвэрлэгдэж байгаа бараа, үйлчилгээний нийт өртөг; |
| Эдийн засагтай холбоотой | Нэг хүнд ногдох ДНБ | Дотоодын нийт бүтээгдэхүүнийг хүн амын тоонд харьцуулсан; |
| Эдийн засагтай холбоотой | Эдийн засгийн өсөлт | Үнийн өсөлтийн нөлөөллийг арилгасан буюу зэрэгцүүлэх үнээр үнэлсэн ДНБ-ний өсөлт; |
| Эдийн засагтай холбоотой | Инфляцийн түвшин | Хэрэглээний сагсыг бүрдүүлж буй бараа, үйлчилгээний үнийн ерөнхий түвшний өсөлт; |
| Эдийн засагтай холбоотой | Гадаад худалдааны эргэлт | Экспорт, импортын нийлбэр; |
| Өртэй холбоотой | Засгийн газрын өр | Өрийн хэрэгслээр үүсгэж, Монгол Улсын засгийн газар, аймаг, нийслэлээс бусдын өмнө хүлээсэн төлбөрийн үүргийг; мөн хууль болон гэрээнд заасны дагуу гаргасан засгийн газрын өрийн баталгааны дүн; |
| Өртэй холбоотой | Засгийн газрын үнэт цаас | Засгийн газраас өрийн удирдлагын тухай хуульд заасан зориулалт, журмын дагуу арилжаалсан өрийн бичиг; |
| Өртэй холбоотой | Зээллэг | Засгийн газрын өрийн баталгаанаас бусад өрийн хэрэгслээр дамжуулан өр үүсгэх; |
| Өртэй холбоотой | Вексель | Төлбөр хариуцагчаас тодорхой хэмжээний мөнгөн хөрөнгийг тогтоосон хугацаанд ямар нэгэн нөхцөл болзолгүйгээр үл маргалдах журмаар вексель эзэмшигчид төлөхийг харилцан тохиролцож баталсан төлбөрийн баримт; |
| Өртэй холбоотой | Концесс | Төрийн, эсхүл орон нутгийн өөрийн өмчийн эд хөрөнгийг дэд бүтцийн болон нийгмийн суурь үйлчилгээг нийтэд үзүүлэх зорилгоор концессын тухай хуульд заасан нөхцөл, журмын дагуу гэрээний үндсэн дээр эзэмших, ашиглах, шинээр бий болгох, шинэчлэн сайжруулах онцгой эрх; |
| Өртэй холбоотой | Засгийн газрын өрийн баталгаа | Баталгаа гаргуулагч нь гэрээнд заасан төлбөрийн үүргээ гүйцэтгэж чадахгүй болсон тохиолдолд төлбөрийг баталгаа гаргуулагчийн өмнөөс төлж барагдуулахаар засгийн газрын хүлээсэн үүрэг; |
| Бусад | Хөтөлбөр | Төсөв хуваарилах зорилгоор үр дүнг нь тооцож, тайлагнаж болохуйц өөр хоорондоо уялдаа бүхий төрийн чиг үүргийг хангахад чиглэсэн багц арга хэмжээ; |
| Бусад | Гадаадын тусламж | Олон улсын байгууллага, түнш орноос засгийн газрын шугамаар, эргэн төлөгдөх нөхцөлгүй, хүмүүнлэгийн болон буцалтгүй, техник туслалцааны хэлбэрээр Монгол Улсад олгож байгаа хөрөнгийн эх үүсвэр; |

**САНГИЙН ЯАМ**
**ИРГЭДИЙН ТӨСӨВ – 2018 ТОВХИМОЛ**
**САНАЛ АСУУЛГЫН ХУУДАС**

*Энэхүү санал асуулга нь цаашид жил бүр хэвлэгдэн гарах Иргэдийн төсөв товхимлыг сайжруулах зорилготой юм.*

**Таны оршин суугаа газар:**

- ☐ Улаанбаатар хот
- ☐ Орон нутаг, *аймгаа бичнэ үү*.......................................
- ☐ Бусад улс, *улсаа бичнэ үү*.......................................

**Таны эрхэлдэг ажил, байгууллага:**

- ☐ Төрийн байгууллага
- ☐ Хувийн хэвшлийн байгууллага
- ☐ Төрийн бус болон иргэний нийгмийн байгууллага
- ☐ Олон улсын байгууллага
- ☐ Хувиараа хөдөлмөр эрхлэгч, малчин
- ☐ Оюутан, сурагч
- ☐ Тэтгэвэрт
- ☐ Бусад, *бичнэ үү*.......................................

**Товхимлыг та ямар хэлбэрээр анх хаанаас авч ашигласан бэ?**

- ☐ Хэвлэмэл
- ☐ Цахим (Сангийн яамны вэб хуудас)
- ☐ Олон нийтийн сүлжээ (Facebook, Twitter гэх мэт)
- ☐ Бусад, *бичнэ үү*.......................................

**Таны иргэншил:**

- ☐ Монгол Улсын иргэн
- ☐ Гадаадын иргэн

**Таны хүйс:**

- ☐ Эрэгтэй
- ☐ Эмэгтэй

**Таны боловсрол:**

- ☐ Дээд
- ☐ Бүрэн дунд
- ☐ Суурь
- ☐ Бага болон боловсролгүй

**Товхимол таны төсвийн мэдлэг, ойлголтыг хэр нэмэгдүүлсэн бэ?**

- ☐ Маш их
- ☐ Хангалттай
- ☐ Дунд зэрэг
- ☐ Бага зэрэг
- ☐ Огт шинэ мэдлэг, мэдээлэл өгөөгүй

**Иргэний төсөв- 2018 товхимлын мэдээллийн агуулгыг хэрхэн үнэлэх вэ?**

| | *Маш сайн* | *Сайн* | *Дунд* | *Хангалтгүй* | *Маш хангалтгүй* |
|---|---|---|---|---|---|
| Бүлэг 1. Төсвийн тухай | | | | | |
| Бүлэг 2. Монгол Улсын 2018 оны нэгдсэн төсөв | | | | | |
| Бүлэг 3. Төсвийн зарлага | | | | | |
| Бүлэг 4. 2018 оны төсвийн онцлог | | | | | |
| Бүлэг 5. Орон нутгийн төсөв | | | | | |

**Иргэний төсөв- 2018 товхимол хэр ойлгомжтой байна вэ?**

| | *Маш сайн* | *Сайн* | *Дунд* | *Хангалтгүй* | *Маш хангалтгүй* |
|---|---|---|---|---|---|
| Агуулгын уялдаа холбоо бүтэц зохион байгуулалт | | | | | |
| Үг хэллэг энгийн ойлгомжтой эсэх | | | | | |
| Зураг дүрслэл мэдээллийг ойлгомжтой болгосон эсэх | | | | | |

| Товхимлын дизайн, уншигдах байдлыг хэрхэн үнэлэх вэ? | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | ***Маш сайн*** | ***Сайн*** | ***Дунд*** | ***Хангалтгүй*** | ***Маш хангалтгүй*** |
| Үсгийн хэмжээ уншигдахуйц байдал | | | | | |
| Зураг дүрслэл, хүснэгт ойлгомжтой | | | | | |
| Өнгөний зохицол | | | | | |
| Хуудасны хэмжээ | | | | | |
| Ерөнхий дизайн, зохион байгуулалт | | | | | |

**Энэхүү товхимол танд ямар ач холбогдолтой гэж үзэж байна вэ?** (*олон сонголттой байж болно*)

☐ Төсвийн талаар мэдлэгтэй болох

☐ Төсөв боловруулах болон батлах үйл ажиллагаанд оролцох

☐ Төсвийн зарцуулалтад хяналт тавих

☐ Судалгаа шинжилгээний ажилд мэдээлэл болгон ашиглах

☐ Ажилдаа ашиглах

☐ Бусад, *бичнэ үү* ……………………………………………………………………………......

**Товхимлыг та ямар хэл дээр ашиглаж байна?**

☐ Англи ☐ Монгол ☐ Аль алинаар нь

**Товхимлын аль хэсэг таньд илүү хэрэгтэй мэдээлэл өгч байна вэ?**

**Товхимлын аль хэсгийн мэдээллийг хэрэгцээгүй гэж үзэж байна вэ?**

**Товхимолд ороогүй боловч ямар мэдээллийг та цаашид авахыг хүсч байна вэ?**

**Бусад санал, хүсэлт**

Та санал асуулгын хуудсыг дараах 2 аргын аль нэгээр бидэнд ирүүлэх боломжтой. Үүнд:

1. Шуудангийн хаяг: Монгол Улсын Сангийн яам, С.Данзангийн гудамж, Засгийн газрын II байр, Д корпус, Улаанбаатар 15160, Монгол Улс
2. Та бөглөсөн санал асуулгын хуудсыг сканердаад эсвэл зургийг нь аваад Сангийн яамны tusuv@mof.gov.mn хаягруу цахим шуудан явуулах

**Судалгаанд оролцсонд баярлалаа**

*Товхимлыг боловсруулж, хянан тохиолдуулсан:*

| | |
|---|---|
| Ерөнхий редактор: | С.Наранцогт - Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга |
| Хянан тохиолдуулсан: | Ж.Ганбат - Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга |
| Боловсруулсан: | В.Рэнцэнханд - Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын ахлах мэргэжилтэн |
| Зөвлөх: | Жон Бартон - АНУ-ын Сангийн яамны төсвийн зөвлөх |
| Англи хэлэнд орчуулсан: | Д.Хангал – Төсвийн зөвлөхийн туслах |

*“Чадамжид суурилсан боловсролыг дэмжих төв” төрийн бус байгууллага нь инфографик, график дизайн, хэвлэлийн эх бэлтгэв. Үүнд:*

Агуулгын боловсруулалт, дизайн: Ц.Ганчимэг

Ерөнхий график дизайнер: Б.Өлзийтөгс

График дизайнер: Г.Сарнай, С.Гарамханд

Хэвлэлийн эх бэлтгэсэн: Б.Алтансүх, М.Даваасүрэн, Б.Мөнхтөр